



**БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

АГУУЛГА БОЛОН ХЭЛИЙГ ИНТЕГРАЦЧЛАН СУРАЛЦАХУЙ (АХИС) - 2

Улаанбаатар хот
2025 он

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

АГУУЛГА БОЛОН ХЭЛИЙГ ИНТЕГРАЦЧЛАН СУРАЛЦАХУЙ (АХИС) - 2

**(Баян-Өлгий аймгийн хос хэлээр хичээл
заадаг ЕБС-ийн багш нарт зориулав)**

Улаанбаатар - Баян-Өлгий
2025

АГУУЛГА

Өмнөх үг

Нэг. АХИС-г эргэцүүлэх нь
Хоёр. АХИС ба сорилт
Гурав. АХИС ба хичээл
Дөрөв. АХИС ба сургуулийн менежмент

Зарим нэр томъёоны тайлбар
Эх сурвалж

ӨМНӨХ ҮГ

Боловсролын сайдын 2025 оны А/229 тушаалаар “Хос хэлний сургалтын талаар баримтлах чиглэл” батлагдсан. Энэхүү чиглэлийг хэрэгжүүлснээр Монгол Улсын казах, тува/цаатан иргэдийн хос хэлний ур чадварыг хөгжүүлэх, тэдний эзэмшиж буй боловсролын чанарыг ялгааг бууруулж, улмаар нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд тэгш оролцох, эх хэл, соёлоо уламжлан өвлөх боломж бүрдэнэ.

Монгол Улсын Баян-Өлгий аймаг болон казах үндэстний цөөнх суурьшсан бүс нутгийн сургалтын орчин нь наад зах нь хоёр хэлт боловсролын орчин бөгөөд сурагчид өдөр тутамдаа казах, монгол хэлний орчинд зэрэгцэн амьдардаг онцлогтой. Иймээс дээрх чиглэлийн 1.2-т тухайн орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтад “3-5 дугаар ангид монгол хэлээр заах судлагдахууныг үе шаттай нэмэгдүүлэх, 6-12 дугаар ангид зарим судлагдахууныг хос хэлээр зохион байгуулах”-аар заасан. Энэ нь казах сурагчдын сурлагын амжилтыг ахиулах, ялангуяа сурагчдын академик хэлний мэдлэг, логик сэтгэлгээ, шинжлэх ухааны ойлголтын түвшнийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.


Сурагчид тухайн хэлний үг болон хэлний дүрмийг зөвхөн цээжлэх бус, шинжлэх ухаан, нийгэм, математикийн судлагдахууны академик хэлийг хэрэглэх чадвар эзэмшихэд сургалтын агуулга болон хэлийг интеграцчлан суралцахуйн арга тусалж чадна. Агуулга болон хэлийг интеграцчлан суралцахуйн (цаашид **АХИС** гэх) нь сурагчийн хэлний хэрэглээг бодит нөхцөлд дэмжиж, шинжлэх ухааны ойлголтыг гүнзгийрүүлэн, шалтгаан үр дагаврын сэтгэлгээг хөгжүүлдгээрээ онцлогтой.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын зарим сургууль дээр АХИС-г туршин нэвтрүүлэх туршилт судалгааны үр дүнд үндэслэн 2022-2023 онд багш, сургуулийн удирдах ажилтнуудад зориулсан анхны гарын авлага-зөвлөмжийг боловсруулсан билээ. Уг гарын авлага-зөвлөмжид АХИС-н тухай ойлголт, АХИС-г нэвтрүүлэхэд багш нарын анхаарах асуудал болон менежмент, удирдлага зохион байгуулалтын талаар, мөн багш нарын боловсруулсан хос хэлт хичээлийн төлөвлөлт зэргийг багтаасан. Энэ удаагийн зөвлөмжид АХИС-н талаар дахин эргэцүүлж, сурагчдад тулгардаг бэрхшээл, түүнийг шийдэх арга зам, АХИС-г нэвтрүүлсэн орон нутгийн болон олон улсын багш нарын сайн туршлагаас илүү тусгасан болно.

Та бүхэн энэхүү зөвлөмжийг сайжруулах санал зөвлөмжөө zulmira@mnier.mn хаягаар ирүүлнэ үү.

НЭГ. АХИС-Г ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Энэ нь заах арга зүй бөгөөд тухайн хичээлийн агуулгыг (жишээлбэл, түүх, байгалийн ухаан, биеийн тамир) сурагчийн эх хэлээс өөр хэл дээр заадаг. Судлаачид “сургах, сурах үйл явцад зөвхөн агуулга дээр, эсвэл зөвхөн хэл дээр биш, харин хоёуланд нь зэрэг анхаарах”-ыг онцолдог. Эдгээр нь хоорондоо нягт уялдаа холбоотой бөгөөд тухайн үед аль нэгэнд нь илүү анхаарал хандуулсан байсан ч гэсэн хоёуланг зэрэг хөгжүүлдэг.



Зураг. Sky_and_Water_I
<https://en.wikipedia.org/wiki/>

АХИС аргыг ашигладаг судлагдахууны багш нь хэлний элементүүдийг хичээлийн агуулгатай уялдуулдаг бол харин хэлний багш хичээлийн агуулгыг хэлтэй уялдуулдаг. М.С. Escher-ийн алдарт модон сийлбэр “Тэнгэр ба Ус I” (1938) нь АХИС арга зүйн агуулга, хэл хоёрын уялдаа холбооны санааг маш сайн дүрслэн харуулдаг гэж судлаачид тайлбарладаг. АХИС-н хувьд та шувуудыг хичээлийн агуулгын элементүүд, загасыг хэлний элементүүд гэж төсөөлж болно. Заримдаа багшийн хувьд та шувууд дээр, өөрөөр хэлбэл, хичээлийн агуулга дээр төвлөрдөг бол, заримдаа загас дээр, өөрөөр хэлбэл хэл дээр төвлөрдөг. Харин заримдаа та хоёуланд нь зэрэг төвлөрч, шувууд ба загас, агуулга ба хэлийг илүү нягт уялдаа холбоотой авч үздэг.

Өөр хэлээр заах ба “өөр хэлээр дамжуулан заах”

Судлагдахууны багш нь хичээлийг зүгээр л өөр хэл дээр заах (өөрийн эх хэл дээр хийдэгтэйгээ яг адилхан байдлаар, зөвхөн өөр хэлээр хийх)

биш, харин өөр хэлээр дамжуулан заах талаар бодоод үзээрэй. Энэ нь юу гэсэн үг вэ? Судлагдахууны багш нар хичээл дээр хэл болон агуулга хоёуланд нь анхаарал хандуулж, суралцагчдад хичээлийн явцад хэл болон агуулгыг зэрэгцүүлэн сурах боломжийг олгоно гэсэн үг юм.

Яагаад АХИС гэж?

- АХИС арга зүйгээр сурсан сурагчид танин мэдэхүйн хувьд хөгжиж, тархи нь илүү их ажилладаг. Танин мэдэхүйн суралцах онолуудын дагуу хүмүүсийн тархи тодорхой даалгаврыг гүйцэтгэхийн тулд илүү их ажиллах шаардлагатай бол тухайн зүйлсийг илүү үр дүнтэйгээр санах магадлал өндөр байдаг. Жишээ нь: хоёр хэлтэй хүмүүс тархиндаа илүү олон холбоос үүсгэж, шинэ холбоос бий болгож, ой санамжаа өргөжүүлдэг. Учир нь тэд хоёр өөр хэлээр суралцаж байдаг. Нэг хичээлийг 2 хэлээр сурах нь сурагчдын тухайн хичээлийн ойлголт, сэтгэн бодох чадвар, бүтээлч сэтгэлгээг өргөжүүлж, гүнзгийрүүлж чадна: тэд хоёр хэлээр суралцах үед тархи илүү их ажиллах шаардлагатай болдог.
- АХИС арга зүйгээр сурсан сурагчид урам зоригтой байдаг. Нэг хичээлийг 2 хэлээр сурах нь тухайн хичээлд урам зориг өгч чадна. Өөр хэлээр заасан хичээл сурагчдад илүү сонирхолтой санагдаж болох бөгөөд учир нь тэд тухайн хичээлтэй хамт хэлний ур чадвараа хөгжүүлж байна гэдгийг мэдэрдэг. Тэд өөр хэл дээр хурдан ахиц гарч байгааг анзаарснаар амжилтыг мэдэрдэг.

- *АХИС арга зүйгээр сурсан сурагчид харилцааны ур чадвараа илүү сайн хөгжүүлдэг.* АХИС-н хамгийн тодорхой давуу тал нь сурагчдын хэлний ур чадвар болон үр дүнтэй харилцах чадвар сайжирдаг явдал юм. АХИС-н ачаар сурагчид ерөнхий болон илүү нарийн агуулгуудын хүрээнд яриа болон бичгийн хэлээ хөгжүүлдэг. Тэд мөн зорилтот хэлийг ашиглан янз бүрийн нөхцөл байдалд (албан ёсны болон албан бус...) харилцааны зорилгодоо хүрч суралцдаг.
- *АХИС арга зүйгээр сурсан сурагчдын хэлний хөгжил илүү хурдан байдаг.* АХИС нь сурагчдад тусгайлсан хэлний хичээлээс илүү үр дүнтэйгээр өөр хэл сурахад тусалдаг. Тэд “амьд” буюу шууд яриа, эсвэл бичлэгтэй яриа, унших материал, дүрслэлтэй хэрэглэгдэхүүн (гарын дохио, эд зүйлс, видео, DVD, гэрэл зураг, зураг) зэрэгтэй ажиллаж, тэдгээрийг боловсруулж, үр дүнг илэрхийлснээр (ярих, бичих) хэлээ хурдан сурч, өндөр түвшний чадвар эзэмшинэ.
- *АХИС арга зүйгээр сурсан сурагчид өөр хэл дээр суралцахад бэлтгэгддэг.* АХИС арга зүйгээр сурсан сурагчид сургуулиа төгсөх үедээ хоёр дахь хэл дээрээ ихээхэн итгэлтэй, чөлөөтэй ярьдаг болдог. Нэмэлт хэлээр үр дүнтэй харилцах чадвар нь сурагчдыг тухайн хэл хэрэглэгддэг орнуудад суралцах, ажиллах, нийгмийн харилцаанд оролцоход бэлтгэдэг.
- *АХИС арга зүйгээр сурсан сурагчид янз бүрийн аргаар сурдаг.* Сурагч бүр өөр өөр байдаг бөгөөд АХИС арга зүйгээр сурсан сурагчид нэг хэлтэй сурагчидтай адил олон янз байдаг. Гол ялгаа нь өөр хэлээр суралцах нь эдгээр ялгааг АХИС арга зүйгээр сурсан сурагчдын хувьд илүү тодорхой болгодог явдал юм. Америкийн профессор Ховард Гарднерийн үзэж байгаагаар дор хаяж найман төрлийн оюун ухааны чадвар байдаг бөгөөд тэр нь хэл, логик-математик, бие-хөдөлгөөн, хараа-орон зайн, хөгжим, байгаль, хүмүүс хоорондын болон дотоод харилцаа юм. АХИС арга зүйг хэрэгжүүлдэг багш нар олон төрлийн суралцах хэв маягт тулгуурлан олон төрлийн оюун ухааны чадварын онолыг ашиглах үед сурагчдад мэдээлэл болон хэлийг олон янзаар боловсруулах, бүтээх боломж олгодог. Энэ нь агуулга болон хэл сурах үйл явцыг бэхжүүлдэг, учир нь сурагчдад агуулга болон хэлийг олон удаа, өөр өөр аргаар дахин харах боломж олгодог. Ингэснээр мэдээлэл болон хэл тархинд хадгалагдаж, сурагчид шинэ нөхцөл байдалд мэдээлэл болон хэлийг илэрхийлэхэд илүү хялбар болдог.

АХИС-н багш болон сургуульд үзүүлэх ач тус

АХИС-г хэрэгжүүлэх нь зөвхөн сурагчдад төдийгүй, багш болон сургуульд ч олон давуу талтай. *Сургуулийн хөгжил ба шинэчлэл*

- АХИС нь бүхэл сургуулийн хэмжээнд шинэчлэл, инновацыг дэмждэг.
- АХИС-г хэрэгжүүлэх нь сургуулийн шинэ хөтөлбөр боловсруулах, сургалтын арга барилыг эргэн харахад хүчтэй түлхэц болдог.

Багшийн ур чадварын хөгжил

- Багш нар өөр хэлээр хичээл заахдаа хэлний ур чадвараа сайжруулж, илүү чөлөөтэй, нарийн мэдлэгтэй хэрэглэгч болдог.
- АХИС-н арга зүйн сургалтад хамрагдсанаар багш нар өөрийн хичээлийг хэрхэн үр дүнтэй заах, сурагчдад хэрхэн ойлгуулах талаар шинэ санаа, шинэ өнцөг олж чаддаг.
- Энэ нь багшийн сэдэв болон хэлний талаарх ойлголтыг өргөжүүлж, илүү гүнзгий мэдлэгтэй болгодог.

Хамтын ажиллагаа

- АХИС нь судлагдахууны болон хэлний багш нарын хамтын ажиллагааг нэмэгдүүлдэг.
- Тэд хичээл дээр хэлний хэрэглээг хэрхэн хөгжүүлэх, эсвэл хичээл хоорондын төсөл дээр хамтран ажиллах боломжтой болдог.

- Сурагчид болон багш нар өндөр түвшний харилцааны ур чадвартай болсноор сургууль нь олон улсын боловсролын төсөлд оролцох, ашиг хүртэхэд илүү бэлтгэгдсэн байдаг.

АХИС-н зорилго нь судлагдахууны агуулгыг сурагчдад эзэмшүүлэх явцад тэдний хэлний мэдлэгийг хамт хөгжүүлэх явдал юм. Ингэснээр сурагчид тухайн судлагдахууны агуулга, нэр томъёог эх хэл болон монгол хэлээр сайтар ойлгож, тайлбарлаж чаддаг болно. АХИС нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Үүнд:

- Сурагчдад судлагдахуунтай холбоотой шинэ мэдээлэл өгөх;
- Сурагчдын судлагдахуун, хэл хоёрыг зэрэг эзэмших боломжоор хангах;
- Сурагчдын хоёрдогч хэлээр ярих өөртөө итгэх итгэлийг дэмжих;
- Хичээлийн явцад сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт, судлагдахууны агуулгыг эхний ээлжинд тавих;
- Хичээлийг хоёрдогч хэлний сургалтын төлөвлөгөөнд нийцүүлэн сурагчдын чадварт тохируулан төлөвлөх;
- Сурагчдын сэтгэх чадварыг бүх талаас нь хөгжүүлэх даалгавар ажиллуулах;
- Сурагчдад судлагдахуун агуулга, хэл хоёрыг зэрэг эзэмших явцад дэмжлэг үзүүлэх;

АХИС-г хичээлд ашиглахдаа:

- Хэлний хичээл биш, хэлний (монгол хэл, казах хэл) сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг чухалчилахгүй;
- Хичээлийг аль нэг хэлэнд орчуулах гэсэн үг биш;
- Судлагдахууны агуулыг заахын зэрэгцээ, хэлний үндсэн 4 чадварыг (сонсох, унших, ярих, бичих) хөгжүүлнэ;
- Идэвхтэй сургалтын аргаар хичээлийг удирдана;
- Ихэвчлэн эх дээр (унших, сонсох, задлах) ажиллана.

АХИС нь үндэсний сургалтын хөтөлбөрийг хөнддөггүй бөгөөд харин түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд хэлний ялгаатай бүлгийн хүүхдүүдэд дэмжлэг болдог.

Тодорхой нэг судлагдахууныг АХИС-гаар заахын онцлог болон давуу тал нь:

- Сурагчид бага ангиасаа тодорхой судлагдахууны агуулга нэр томъёог монгол хэлээрээ эзэмшихийн хамт, эзэмшсэн чадвараа эх хэл дээрээ хөгжүүлэх боломжтой болно. Энэ нь монгол хэлийг зөвхөн монгол хэлний хичээлээр эзэмшүүлэхтэй харьцуулахад, сурагчдад олон шинэ боломж олгоно. Учир нь сурагчид хэл сурахын зэрэгцээ, судлагдахууныг хамт судална. Өөрөөр хэлбэл, унших, сурах, сэтгэх чадварууд интеграцчиллагдан гэсэн үг.
- Мөн АХИС нь багшид шинэ шаардлага тавина. Тус аргаар хичээл заадаг багш нь тухайн судлагдахууны мэргэжлийн багш, хэлний багш, анги удирдсан багш, туслах багшийн үүргийг нэг дор гүйцэтгэж чаддаг байх хэрэгтэй болно.

Багшид тулгардаг томоохон бэрхшээл бол багшийн өөрийн мэргэжлийн ур чадвар маш сайн байхын зэрэгцээ 2 хэлний чадвар бас өндөр байх шаардлага юм. Энэхүү бэрхшээлийг даван туулах нэг арга зам нь судлагдахууны болон хэлний багш нар хамтран ажиллах явдал юм.

Агуулга болон хэлийг интегрчилан суралцахуй – АХИС, 2022

ХОЁР. АХИС ба СОРИЛТ

АХИС-н үед сурагчдад ямар бэрхшээл сорилт тулгардаг вэ?

АХИС-н орчинд сурагчдад тулгардаг бэрхшээлийг танин мэдэж, түүнд анхаарлаа хандуулах нь тэдэнд үзүүлэх дэмжлэг, багшийн заах арга зүйг тодорхойлох чухал хүчин зүйл юм.

а) Хэлний болон судлагдахууны агуулгын хувьд тулгардаг бэрхшээл

Тухайн хичээлийн агуулгыг ойлгоход шаардлагатай тусгай үгсийн сан, мэргэжлийн хэллэг сурагчдад хүндрэлтэй байдаг. Жишээ нь, математикийн хичээлд “тэгшитгэл”, “хувьсагч”, түүх, нийгмийн ухааны хичээлд “баримт”, “үзэл бодол” гэх мэт үгсийг зөв ойлгоогүй бол бодлогыг бодож чадахгүй, эх сурвалжийг шинжлэхэд хүндрэлтэй байх болно. Энэ төрлийн бэрхшээл нь сурагчдын тухайн хэлний үгсийн сангийн нөөц, өгүүлбэрийн бүтцийн мэдлэг, хэрэглээ, академик хэллэг, түүнийг ойлгох байдалтай холбоотой байдаг. Тухайлбал,

- Цогцолбор, эх зэрэг нэг өгүүлбэрээс урт, яриа эсвэл бичгийн хэллэг сурагчдад ойлгох, эсвэл өөрсдөө бүтээхэд хүндрэлтэй байж болно. Жишээ нь: сонины нийтлэл, видео бичлэг, тайлбар, лекц, г.м. Тэдэнд тулгардаг сорилт нь:
 - Урт эхийн логик холбоог ойлгох;
 - Гол санааг ялгаж авах;
 - Өөрийн санаагаа урт, зохион байгуулалттай хэлбэрээр илэрхийлэх зэрэг байна.
- Унших, сонсох, үзэх үед АХИС сурагчдын тулгардаг сорилтууд:
 - Шинэ, нарийн төвөгтэй, бодит эсвэл хийсвэр мэдээллийг зураглалын дэмжлэггүйгээр боловсруулах; Жишээ нь, инфляцын тухай санхүүгийн мэдээлэл (эдийн засаг).
 - Хүснэгт, диаграмм, график, зураглал зэрэг тайлбаргүй дүрслэлийн дагуу мэдээлэл хийх; Жишээ нь: хур тунадасны гистограмм (газар зүй).
 - Зураг тайлбарлах, эх сурвалжийн мэдээллийг аргыг ойлгох; Жишээ нь: хуучин газрын зураг, хуучин эх, эд, өлгийн зүйлс (түүх, урлаг) (түүх).
 - Баримт ба санал бодлыг ялгаж, жишээ нь: “Чингис хаан бол монгол хүн” (баримт) ба “Тэр мянганы суут хүн” (санал бодол).

Сурагчид ярих, бичихдээ логиктой бүтэц гаргах, үг хэллэгийг зөв сонгох, сонсогчдод ойлгомжтой илэрхийлэх зэрэг олон талын сорилттой тулгардаг.

Хүснэгт. Сурагчдад тулгардаг хэлний бэрхшээл

Бэрхшээл	Тайлбар	Жишээ
Академик үгийг ойлгохгүй байх	Шинжлэх ухааны нэр томъёо, абстракт ойлголттой үгс сурагчдад хүнд	“тэгшитгэл”, “хувьсагч” “баримт”, “үзэл бодол” гэх үгсийг дахин давталтгүй ашиглаж чадахгүй.
Өгүүлбэр бүтээх чадвар сул	Агуулгыг мэдсэн ч зорилтот хэл дээр илэрхийлж чадахгүй	“Баримт нь бол үзэл бодол нь байдаг” гэх мэтээр өгүүлбэр бүтээж чадахгүй байх, илэрхийлэхдээ гацах.
Асуулт тавьж чадахгүй байх	Хэлний дутагдлаас болж танин мэдэхүйн дээд түвшний ойлголтын асуулт асуухгүй	“Яагаад? Ямар учраас, Хэрхэн?” зэрэг асуух үгсийг ашиглан асуулт тавихын оронд чимээгүй суух
Агуулгыг буруу ойлгох	Үгс, зааврыг ойлгохгүйгээс агуулгын гүйцэтгэл буурах	Монгол хэлээр өгсөн даалгавар, зааварчилгааг буруу ойлгох, эсвэл казах хэлээр өгсөн даалгавар, зааварчилгааг монгол хэлэнд оновчгүй хөрвүүлж ойлгох
Агуулга ба хэлний зорилго хамт тулхад будилах	Аль нь хэлний, аль нь агуулгын хүрэх үр дүн болохыг ялгаж ойлгохгүй	Агуулга гэхээс илүү үг цээжлэхэд төвлөрөөд гол ойлголтоо алдах

b) Сэтгэл зүйн хувьд тулгардаг бэрхшээл

Сурагчид хоёр дахь хэлээр сурах явцдаа сэтгэлзүйн олон сорилттой тулгардаг. Энэ нь тэдний сонсох, унших, ярих, бичих чадварын хөгжилд шууд нөлөөлдөг. Өөр хэлээр суралцахдаа сурагчдад *итгэлгүй, айдастай, хүчгүй, эргэлзээтэй, бүр инээдтэй санагдах* мэдрэмж төрж болно. Энэ нь тэдний *анхаарал төвлөрөлт, тэвчээр, сурах эрмэлзэлд* сөргөөр нөлөөлнө. *Итгэлгүй байдал* нь ярих, бүтээлчээр бичих оролдлогыг багасгадаг. Ярихдаа *алдаа гаргах вий гэж эмээх* нь идэвхтэй оролцоог бууруулдаг.

Сурагчдаа ажиглаарай

- | | |
|------------------------------|---|
| - гараа өргөхөөс зайлсхийх | - хэлний түвшин сайтай сурагч давамгайлах |
| - буруу хэлэхээс айх | - сул хэлтэй сурагч “чимээгүй ажиглагч” болох |
| - ойлгохгүйгээ хэлэхгүй нуух | - багийн ажилд жигд оролцохгүй байх |
| - ганцаардах мэдрэмж төрөх | |

Бэрхшээл	Тайлбар
Буруу хэлэхээс айх, ичих	Хэлний алдаа гаргах нь ичгэвтэр санагдаж оролцоо сулрах, багшийн зэмлэл, бусад сурагч шоолохоос айх;
Өөртөө итгэх итгэл сул байх	“Би энэ сэдвийг ойлгоогүй” гэж хэлэх боловч үнэндээ хэлний асуудлаас болж өөртөө итгэлгүй байх;
Хичээлд дарамттай санагдах	Хос хэлний ачааллаас болж сурах хүсэл буурах, шинэ сэдэв дээр 10 шинэ үг зэрэг орж ирэхэд сурагчийн ачаалал нэмэгдэж, анхаарал сарних;
Өөрийгөө дутуу үнэлэх, оролцохгүй байх	Сайн ярьдаг, хэлний түвшин сайтай хүүхдүүдээс санаа зовж ярихгүй байх;

АХИС ба багш

АХИС-н үед судлагдахууны агуулга болон хэлний чадварыг хөгжүүлэх боломжийг ашиглахын тулд багш нар олон талын ур чадвараа хөгжүүлэх шаардлагатай байдаг бөгөөд багш нар ч багагүй сорилт бэрхшээлийг даван туулдаг. АХИС-н чадварлаг багш болох хугацаа нь багш нарын өөрсдийн *урам зориг, цагийн боломжоос* хамаарна. Мөн үүнд сургуулийн дэмжлэг, хамтын ажиллагаа чухал нөлөөтэй.

АХИС-н хичээлийн багш нар хөгжлийн явцад хэд хэдэн үе шатыг дамжин өнгөрдгийг Liz Dale, Rosie Tanner нарын “CLIL Activities” гарын авлагаас хүргэж байна. Энэ нь багш өөрийн хөгжлийн үе шатаа тодорхойлж, мэргэжлийн хувьд өсөн дэвжих арга замаа төлөвлөх ач холбогдолтой юм.

1-р үе шат: Багш өөрийн хэлний ур чадвараа хөгжүүлэх

Эхний үе шатанд багш нар өөрийн эх хэлний болон зорилтот хэлний ур чадвар, хэлний мэдлэгтэй итгэлгүй байж болно. Энэ үед багш өөртөө дараах асуултуудыг тавьдаг. Үүнд:

- Миний хэлний ур чадвар өөр хэл дээр хичээл заахад хангалттай сайн болох болов уу?
- Би өөрөө болон миний сурагчид хэр их шинэ үгс сурах хэрэгтэй вэ?
- Надад хэрэгтэй үгсийг хаанаас олж болох вэ?
- Хэрэв сурагчид хэлний талаар асуулт асуухад би тэр даруй хариулж чадахгүй бол яах вэ?
- Миний хэлний ур чадвар хангалтгүй бол нэр хүндээ алдах болов уу?

Энэ үед судлагдахууны багш нар АХИС-н багшийн үүргээ *сурагчдад тухайн хичээлтэй холбоотой үгийн жагсаалт өгч сургах* гэж ойлгох хандлагатай байдаг. Өөрийн хэлний ур чадвар, мэдлэгийн хөгжилд анхаарч байгаа нь тэднийг өөртөө төвлөрүүлэхэд хүргэдэг бөгөөд

ингэснээр хичээлийг багш төвтэй заах, зохион байгуулах хандлага давамгайлж, сурагчдыг идэвхжүүлэхэд бага анхаарах хандлага ажиглагддаг.

Анхаарлыг багшаас сурагч руу шилжүүлж, сурагчдыг хооронд нь харилцахыг урамшуулах нь багшийн хэлний ур чадварын талаарх түгшүүрийг багасгадаг. Өөрийн хэлний ур чадварын түвшнээс илүүтэйгээр сурагчдыг хоёр дахь хэлээ ашиглахад урамшуулах нь судлагдахууны багшийн хөгжлийн чухал алхам юм. Багшийн хэл нь сурагчдын хэл сурах цорын ганц эх сурвалж биш юм. Багш сурагчид телевиз, радио, интернэт, хэвлэгдсэн сургалтын материал зэрэг эх сурвалжаас авсан аудио, видео болон бичгийн материал ашиглан *чөлөөтэй, зөв яриа болон бичгийн хэлний жишээг* хангаж чадна гэдгээ ойлгох хэрэгтэй.

Багшид тулгардаг зарим асуудал

“Би монголоор ярихдаа итгэлгүй байдаг. Заримдаа сурагчид хүртэл намайг засдаг.”

Сурагчид зорилтот хэлийг хэрэглэж байгаа нь илүү чухал. Таны үг хэллэгийг зассан тохиолдолд тэдэнд баярлаж, наргиа болгон хүлээж аваарай. Өөрийн монгол хэлээ сайжруулахын тулд хэлний сургалтад хамрагдах боломжийг судалж, хэрэгжүүлээрэй.

Мөн хос хэлийг шинээр сурч буй сурагчдын хувьд зорилтот хэлтэй багшийг илүү ойлгомжтой гэж үзэх нь бий. Харин хоёр хэлээр заадаг багш хичээлээ сурагчдын хэлний түвшинд тохируулан заахгүй бол ойлгоход илүү хэцүү байж болно. Зорилтот хэлээр заадаг багш нар өөрсдөө ижил төстэй бэрхшээлтэй тулгарч байсан учраас сурагчдад хоёр дахь хэл дээр тулгарч буй зарим асуудлыг илүү сайн ойлгож, дэмжлэг үзүүлэх боломжтой байдаг.

АХИС-н эхний шатанд багшийн хэлний түвшнээс илүүтэй сурагчдыг хоёр дахь хэлээ ашиглахад урамшуулах, олон төрлийн эх сурвалжаас хэлний мэдээлэл өгөх нь чухал бөгөөд энэ нь багшийн хөгжлийн дараагийн шат руу шилжих суурь болдог.

2-р үе шат: Сурагчдын үгийн санг нэмэгдүүлэх

Багш нар өөрийн хэлний ур чадвар нь сурагчдын суралцах үйл явцад ямар нөлөөтэй болохыг ойлгож, итгэлтэй болсон үедээ хоёр дахь шат руу шилждэг. Энэ шатанд тэд өөрсдийгөө зөвхөн судлагдахууны багш бус, хэлний багш гэдгээ илүү ухамсарлаж эхэлдэг.

- Тэд сурагчдыг хэл сурахад урамшуулж, голчлон шинэ үгсийн нөөцөө нэмэгдүүлэхэд анхаардаг.
- Сурагчдад шинэ үг, хэллэгийг сурч эзэмшихэд туслах олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулдаг.
- Багш нар өөрийн хэлний ур чадвартаа илүү итгэлтэй болж, алдаа гаргахаас санаа зовохоо багасгадаг.
- Тэд сургалтын материалдаа сурагчдад хүндрэл учруулдаг хэлний талуудыг анзаарч, эдгээрийг даван туулахад туслах анги доторх үйл ажиллагааны нөөцийг бий болгохыг зорьдог.

Энэ шатанд багш нар хэлний багшийн үүргээ илүү ухамсарлаж, сурагчдын үгийн санг баяжуулахад чиглэсэн олон талын арга, аргачлал ашиглаж эхэлдэг. Үүний үр дүнд АХИС хичээлийн чанар мэдэгдэхүйц сайжирдаг.

3-р үе шат: Сурагчдын хэлний хэрэглээг дэмжих

Энэ шатанд туршлагатай багш нар хэл нь зөвхөн үгийн сангаас бүрдэхгүй гэдгийг ухамсарлаж, өөрийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг зөвхөн агуулгын материал бус, хэл сурах материал гэж харж эхэлдэг.

- Тэд янз бүрийн бичих, ярих үйл ажиллагааг урамшуулдаг.

- Ярианы болон бичгийн хэлний ялгаа, албан ёсны болон албан бус хэлний ялгааг илүү ажигладаг.
- Өөрийн судлагдахууны хэлний (үгсийн сан, дүрэм, функц, шалгалтын төрөл гэх мэт) талаар илүү мэдлэгтэй болж, сурагчдыг хэл сурахад хэрхэн дэмжихээ ойлгодог.
- Энэ шатанд багш нар өөрийн хэлний ур чадварт бага санаа зовж, сурагчдын асуултад уян хатан хариулах аргуудыг хөгжүүлдэг.
- Тэд оролтыг (input) янз бүрийн түвшинд тохиромжтой эсэхийг үнэлж, сурагчдад хэлээ ойлгож, хөгжүүлэхэд туслах олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Сурагчдад өдөр тутмын харилцааны ур чадварыг зааж, академик хэлний чадварыг хөгжүүлэхэд нь тусалдаг.

Багшид тулгардаг зарим асуудал

“Миний сурагчид монголоор чөлөөтэй ярьж чаддаг. Гэвч тэд нар яагаад академик хэлийг ойлгож, хэрэглэж чадахгүй байна вэ? Би ярихдаа академик хэлийг хэрхэн хөгжүүлэх вэ?”

Сурагчид өдөр тутмын яриандаа зорилтот хэлээр чөлөөтэй ярьж чаддаг болов ч, академик хэл нь илүү нарийн ойлголт, мэргэжлийн үг хэллэг, албан ёсны бүтэц шаарддаг. Академик хэлийг хөгжүүлэхийн тулд:

- Сэдэвтэй холбоотой *мэргэжлийн үг хэллэг, холбоосуудыг* тогтмол хэрэглээрэй.
- Сурагчдад *тус болох өгүүлбэрийн эхлэлүүдийг* санал болгоорой: *“Нотолгоо харуулж байна...”, “Харьцуулбал...”, “Энэ нь ...-г харуулж байна” гэх мэт.*
- *Бүтэцтэй ярианы даалгавар* ашиглаарай: мэтгэлцээн, илтгэл, мэдээллийн зөрүүтэй даалгавар.
- *График зохион байгуулагч* (Венн диаграмм, хүснэгт) ашиглаж, ярихаасаа өмнө санаагаа зохион байгуулахад нь туслаарай.
- *Бодох хугацаа* өгч, сурагчдад урьдчилан бэлтгэх боломж олгоорой.
- Багийн ажил дээр зарим сурагчдад **хэлний хэрэглээг хянах** үүрэг өгч, бусдыг академик хэлийг хэрэглэхэд чиглүүлээрэй.

Сурагчдыг өдөр тутмын ярианаас *академик хэл рүү шилжүүлэхийн тулд багш нь загвар үзүүлэх, бүтэцтэй даалгавар өгөх, ашигтай хэллэгээр дэмжих* хэрэгтэй.

АХИС ба судлагдахууны болон хэлний багш нарын хамтын ажиллагаа, чиг хандлага

АХИС нь багш нарын дунд хамтран ажиллах шинэ соёл, арга хандлагыг төлөвшүүлдэг. Учир нь сурагчдынхаа амжилттай суралцахуйг дэмжихийг тулд нь хэлний багш нар зөвхөн хэлээ, судлагдахууны багш нар зөвхөн тухайн агуулгаа заах бус харин хичээлийн агуулга болон хэлний хэрэглээг уялдуулан сурагчдыг дэмжих нь тэдний хос хэлний чадварыг хөгжүүлж чадахыг багш нар ойлгодог.

АХИС-г хэрэгжүүлж эхлэх үед хэлний багш нарыг ихэвчлэн:

- Хамтран ажиллагсдынхаа бичгийн ажил, шалгалтын хэлний хэсгийг засах;
- Заримдаа хичээлд нь ажиглалт хийж, хэлний талаар санал өгөх байдлаар хамтран ажилладаг.

Энэ нь дээр дурдсан *1-р үе шаттай* холбоотой бөгөөд тухайн үед хичээлийн багш нар өөрийн хэлний ур чадвартаа итгэлгүй байдаг. Энэ үед мөн хэлний багш нар ч өөрийн *хичээлийн мэдлэг, тусгай нэр томъёоны талаар* санаа зовдог. Жишээлбэл, тэд физик, хөгжим, биеийн тамирын чиглэлээр мэргэшсэн сургалт аваагүй тул тухайн судлагдахууны ойлголт, нэр томъёог бүрэн ойлгохгүй байж болно.

Энэ асуудлыг шийдэх нэг арга бол *хэлний болон судлагдахууны багш нарын нягт хамтын ажиллагаа* юм.

- Зарим сургууль хоёр ба түүнээс олон хичээл болон хэлний хамтарсан богино хугацааны үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

- Зарим нь бүхэл бүтэн АХИС арга зүйн долоо хоног зохион байгуулж, сурагчид тухайн сэдвийг хэлний болон судлагдахууны хичээл дээр зэрэг судалдаг.
- Багш нар эхлээд тухайн сэдвийн дагуу хамтдаа оюуны зураглал хийж, дараа нь холбогдох үйл ажиллагаа боловсруулдаг. (Жишээ нь: усны тухай судлагдахууны болон хэлний багш нарын хамтран хийж болох оюуны зураглалыг харна уу.)

Эдийн засаг

- Устай холбоотой эдийн засгийн хөгжил: Уул уурхайн ус ашиглалт, гол мөрөн, цөл, ойжуулалт - Тэрбум мод хөдөлгөөн
- Дэлхийн дулаарал ба нүүрстөрөгчийн хийн ялгарал;
- Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF);

Хөгжим

- Усны сэдэвтэй дуу хөгжим (жишээ нь: Сэлэнгэ мөрөн, Ховд, Завхан гол);
- Устай холбоотой хөгжмийн зэмсэг хийх (жишээ нь: ус дүүргэсэн шил, сав);

Физик

- Уурын хөдөлгүүр
- Давалгаа - Усан цахилгаан станц
- Ус халаагч
- Усны гулсуур ба физикийн хууль

Хэл

- Усны сэдэвтэй зохиол, яруу найраг (жишээ нь:)
- Үер, ган гачиг, далайтай холбоотой роман эсвэл кино (жишээ нь: Үер);



Хими

- Усны шинж, химийн тэмдэг - H₂O
- Цахилгаан ба ус
- Ph түвшин

Газарзүй

- Усны эргэлт
- Хур тунадас, үер ба ган гачиг
- Гол мөрөн ба далай тэнгис

Урлаг ба дизайн

- Усыг дүрсэлсэн уран бүтээлчид
- Усан дээр туссан гэрэл зураг
- Урлаг дахь усны бэлгэдэл
- Усны өнгө

Биологи

- Усны амьтан ба ургамал
- Хүний биеийн устай холбоотой байдал (шингэн дутагдал, шумбах үеийн хүйтэн цочрол)

Түүх

- Усны тээрэм ба Аж үйлдвэрийн хувьсгал
- Лондонгийн Их түймэр ба усны менежментэд үзүүлсэн нөлөө
- Эртний улсуудын усан хангамжийн систем

Хөгжлийн дараагийн шатанд хэлний багш нар:

- Хэл болон судлагдахууныг нэгтгэх боломжийг илүү ухамсарлах,
- Судлагдахууны сургалтыг хэлний хичээлээр дэмжих шаардлагыг ойлгодог болно.

Тэд сурагчид судлагдахууны хичээл дээр монгол хэлийг хангалттай судалж, төрөл бүрийн эх сурвалж, мэдээлэлтэй ажиллаж байгааг олж харах болно. Тиймээс өөрсдийн хэлний хичээл дээр *академик хэлний даалгавар* дээр төвлөрч, судлагдахууны хэрэглэгдэхүүнтэй холбож ажиллах нь сурагчдад илүү ач холбогдолтой болохыг ойлгож авна. Энэ үед хэлний болон судлагдахууны зарим багш нар хичээлээ хамтдаа төлөвлөж, хамтран заах боломжтой болдог.

Судлагдахууны багш, хэлний багш нарын хамтын ажиллагаа олон хэлбэртэй байж болно. Жишээ нь:

- *Судлагдахууны багш нар* өөрсдийн боловсруулсан даалгавар, шалгалтыг материалыг хэлний багш нарын засвар, зөвлөгөөнд тулгуурлан сайжруулдаг.
- *Хэлний багш нар* судлагдахууны хэлний хэрэглээг өөрийн хичээлдээ тусгаж, сурагчдын сурах үйл явцыг дэмждэг.

- Зарим сургуульд судлагдахууны болон хэлний багш нар нэгэн зэрэг, нэг бүлгийн сурагчдад хамтран хичээл заах боломжтой байдаг.

Хамтын ажиллагаа нь хичээлийн өмнө, хичээлийн явцад, эсвэл дараа нь явагдаж болох бөгөөд энэ нь АХИС-н сургалтын чанарыг бүхэлд нь сайжруулахад чухал үүрэгтэй.

Хичээлийн өмнө хэлний багш дараах зүйлсийг хийх боломжтой:

- Судлагдахууны багштай хамтран ажиллахдаа хичээлийн агуулгад тохиромжтой хэрэглэгдэхүүнийг олох, түүний хэлний түвшнийг үнэлэх, боломжит даалгавар эсвэл асуулт зохиох;
- Судлагдахууны багшийн боловсруулсан даалгавар, шалгалтын хэлний хэсгийг засварлах;
- Үйл ажиллагаанд хэрэглэж буй хэлний хэрэглээг тодорхойлох (жишээлбэл: тайлбарлах, шалтгаан-үр дагаврыг илэрхийлэх, мэтгэлцээн зэрэг хэлний үүрэг; үйл ажиллагаанд хэрэглэж буй дүрэм; холбогдох үгсийн сан эсвэл дуудахад хэцүү үгс) ба дараа нь тухайн хэлний хэрэглээг сурагчидтай урьдчилан заах эсвэл дадлагажуулах;
- Сурагчид тухайн үйл ажиллагаанд ямар төрлийн эх дээр ажиллаж байгааг тодорхойлоод, энэ төрлийн эх дээр нийтлэг хэрэглэгддэг хэлний хэрэглээг судлах;
- Үйл ажиллагаанд хэрэглэж буй тодорхой хэлний чадварыг (унших, сонсох, ярих, бичих, толь ашиглах чадвар) тодорхойлоод, сурагчдыг дадлагажуулах;
- Үйл ажиллагаанд шаардлагатай суралцах стратегиудыг (жишээлбэл: эхийг уншихдаа зураг, гарчиг ашиглах гэх мэт) тодорхойлоод, сурагчдаа хамт дадлагажуулах;
- Сурагчид үнэлгээний шалгуурыг урьдчилан ойлгоход үнэлгээний рубрикийг танилцуулж, ашиглах.

Хичээлийн явцад хэлний багш дараах зүйлсийг хийж чадна:

- Сурагчдын хэлний бүтээлийг ажиглаж, дэмжлэг үзүүлэх;
- Сурагчдын хэлний сайн жишээнүүдэд санал, зөвлөгөө өгөх;
- Хэлний түгээмэл алдааны талаар зөвлөгөө өгөх;
- Сурагчдын хэлний асуудлыг тэмдэглэж, хэлний хичээл дээр ажиллах;
- Ангидаа тухайн үйл ажиллагаатай холбоотой хэл сурах стратегийн талаар заавар өгөх эсвэл сануулах;
- Асуулт асууж, хэрэгтэй хэлний хэрэглээг өдөөж, сурагчдын ярихыг дэмжих;
- Сурагчдын бичгийн ажлыг цуглуулах эсвэл ярианы ажлыг видео/аудио бичлэгээр хадгалах;

Хичээлийн дараа хэлний багш дараах зүйлсийг хийж чадна:

- Хэлний асуудалд санал зөвлөгөө өгөх эсвэл засах, хичээл заах;
- Сурагчдын хэлний бүтээлд зөвлөгөө өгөх (жишээ нь: сурагчдын алдааг самбар дээр бичих эсвэл гарын авлага хийх);
- Хэлний нэмэлт үйл ажиллагаа зохион байгуулах (жишээ нь: дүрэм, үгсийн сан, дуудлага);
- Хэлний чадвартай холбоотой нэмэлт үйл ажиллагаа зохион байгуулах (сонсох, үзэх, унших, бичих, ярих) – судлагдахууны багшийн хийсэн практик үйл ажиллагаатай холбох;
- Сурагчдын бичгийн ажил эсвэл ярианы аудио бичлэгийг шалгаж, нийтлэг хэлний асуудлыг тэмдэглээд, дараагийн хичээл дээр төвлөрөх;
- Хичээлийн хэрэглэгдэхүүнийг хэлний хичээлд оролт болгон ашиглах.

Хэлний болон судлагдахууны багш хамтдаа сурагчдын хийсэн ажлыг үнэлж, хамтарсан үнэлгээ өгч, дүн тавих боломжтой.

Рубрик: АХИС дахь хэлний болон судлагдахууны багшийн хамтын ажиллагаа

Нөхцөл байдал	Хамтын ажиллагаа сул			Хамтын ажиллагаа нэмэгдсэн
	1	2	3	4
Хэлний болон судлагдахууны багшийн харилцаа	Эдгээр багш нарын хамтын ажиллагаа дутмаг байдаг	Судлагдахууны багш нар хэлний мэдлэгийн тодорхой түвшинд хүрсний дараа хэлний чадвараа цаашид сайжруулахад төдийлөн анхаардаггүй. Хэлний болон судлагдахууны багш нарын хооронд хэлний талаар албан бус харилцаа л явагддаг.	Хэлний багш нар судлагдахууны багш нарын хэлний хэрэглээ, сургалтын хэрэглэгдэхүүн болон шалгалттай холбоотой асуултад хариулна. Судлагдахууны багш хэлний багшид хэлтэй холбоотой асуултаа тавих боломжийг олгодог.	Эдгээр багш нар тогтмол, нягт хамтран ажилладаг. Хэлний багш хааяа судлагдахууны багш нарын хичээлд сууж, хэлний хэрэглээний талаар санал, зөвлөгөө өгдөг. Судлагдахууны багш нар хэлний ур чадвараа хөгжүүлэх зорилгоор сургалт, семинарт хамрагддаг. Эдгээр ажлыг гүйцэтгэхэд зориулан багш нарт долоо хоногт тодорхой тооны цагийг албан ёсоор хуваарилсан байдаг.
Сурагчдад үзүүлэх дэмжлэг	Судлагдахууны болон хэлний багш нар сурагчдад өгөх зөвлөгөө, мэдээллийн талаар ярилцдаггүй.	Судлагдахууны багш нар хааяа сурагчдын яриа болон бичгийн алдааг анзаарч, засаж өгдөг.	Судлагдахууны багш нар хааяа сурагчдын яриа болон бичгийн хэлэнд гаргадаг алдааг засахад туслах зорилгоор даалгавар, зөвлөгөө өгдөг.	Судлагдахууны багш нар сурагчдын байнга гаргадаг хэлний алдаануудыг хэлний багшид мэдээлдэг. Хэлний багш (эсвэл хэлний болон хичээлийн багш нар хамтран) эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор сурагчдад зориулсан даалгавар боловсруулдаг.
Багш нарын яриа болон бичгийн хэлний хэрэглээ	Судлагдахууны багш нар өөрсдийн эх хэлээр ажиллаж, уулзалт зохион байгуулдаг.	Тэд хурал дээр болон хэлний багш нартай харилцахдаа зорилтот хэлээр ярьдаг боловч, сургуулийн орчинд зорилтот хэлээр ярьдаггүй.	Судлагдахууны багш нар хоорондоо зорилтот хэлээр ярихыг зорьдог боловч сурагчдын эмзэг асуудал, мэдрэмжтэй холбоотой харилцааг хялбарчлах үүднээс эх хэлээр хэлэлцдэг. Харин хэлний багш нар тэдэнтэй үргэлж (эсвэл хичээж) зорилтот хэлээр харилцдаг.	Судлагдахууны багш нар үргэлж зорилтот хэлээр харилцдаг. АХИС-н хичээл ажиглалт, тэмдэглэл, мэдээллийн хуудас зэрэг баримтуудыг сурагчид сурч буй хэл дээр тараадаг. Хэлний багш нар бусад багш нартаа хэл сурахад зориулсан ном, вэб сайтуудыг санал болгодог.

Сургуулийн орчны хэл	Хэлний болон судлагдахууны багш нар тус тусын хөтөлбөр дээрээ ажилладаг. Тэд хэл болон хэл заах арга зүйн талаар хамтран ярилцдаггүй. Энэ нь сургуулийн хэмжээнд төдийлөн асуудал гэж тооцогддоггүй.	Судлагдахууны багш нар хааяа судлагдахууны хэлтэй холбоотой дэмжлэгийг хэлний багш нараас хүсдэг. Арга зүйтэй холбоотой асуудлыг хурал дээр эсвэл багш нарын өрөөнд албан бусаар хэлэлцдэг. Сурагчид зориулсан үгсийн сангийн жагсаалт (толь бичиг) бэлтгэдэг.	Судлагдахууны багш нар сурагчдын хэлний асуудлын талаар хэлний багш нартай ярилцдаг, хэлний багш нар судлагдахууны багш нарын хүсэлтийг хүлээн авч, ажилладаг. Сургуулийн орчинд үгсийн сан (толь бичиг) ашиглахтай холбоотой зарчим байдаг бөгөөд зарим багш нар энэхүү зарчмыг баримталдаг.	Хэлний багш нар (эсвэл арга зүйч, сургагч) хамтран ажиллагч багш нартаа хэлний талаар сургалт, семинар зохион байгуулдаг. Хэлний багш нар судлагдахууны багш нарт хичээлдээ хэлний зорилго, хэлний үйл ажиллагааг тусгах талаар зөвлөдөг. Хэлний туслах ажилтнууд хичээлд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлдэг. Үгсийн сан (толь бичиг) ашиглахтай холбоотой тодорхой бодлого, тохиролцоо байдаг бөгөөд бүх судлагдахууны багш нар өөрсдийгөө зөвхөн тухайн судлагдахууны багш биш, хэлний багш гэж үздэг бөгөөд хэл сурах үйл явцад хэлний үүргийг бүрэн ойлгодог.
Сургалтын хөтөлбөр	Хэлний багш нар судлагдахууны багш нарын хөтөлбөртэй хамааралгүй, тусдаа сургалтын хөтөлбөрөөр хичээл заадаг. Тэд өөрсдийн хөтөлбөр, хэрэглэгдэхүүний дагуу бие даан ажилладаг.	Хэлний болон судлагдахууны багш нар хөтөлбөрийн агуулга, сургалтын материалын талаар заримдаа албан бус, тохиолдлоор хамтран ажилладаг.	Судлагдахууны болон хэлний багш нар хөтөлбөр, сургалтын материал боловсруулахад тодорхой хэмжээгээр хамтран ажилладаг. Энэхүү хамтын ажиллагааг дэмждэг боловч албан ёсоор тогтсон бүтэц, дүрэм журам байхгүй.	Хэлний багш нар судлагдахууны багш нартай хамтран тухайн хичээлийн хэлний хэрэглээтэй холбоотой материал боловсруулах, өөрчлөхөд тусалдаг. Хэлний болон судлагдахууны багш нар хамтран хичээл хоорондын уялдаатай төслүүдийг зохион байгуулж, эдгээр нь жилийн турш тодорхой хугацаанд эсвэл тодорхой долоо хоногуудад хэрэгждэг. Зарим тохиолдолд хэлний болон судлагдахууны багш нар хамтран хичээл заадаг.

Эх сурвалж. «CLIL Activities»

ГУРАВ. АХИС ба ХИЧЭЭЛ

АХИС хичээлийн багш нар өөрийн хичээлд хэлийг хэрхэн ашигладгийг тодорхой ойлгож байх нь чухал. Ингэснээр тэд сурагчдад тухайн хичээлд хэл хэрхэн хэрэглэгдэж байгааг ажиглахад тусалж, хичээлийн хэлтэй холбоотой тодорхой сорилтуудыг даван туулахад нь дэмжлэг үзүүлж чадна. Судлагдахууны багш хэл заах шаардлагагүй боловч зорилтот хэлээр ойлгоход шаардлагатай хэлний дэмжлэгийг төлөвлөх чадвартай багш байх ёстой. Энэ нь хичээлийн үр дүнг 1) агуулгын ойлголт 2) академик хэлний хэрэглээ хоёрт чиглүүлдэг.

Мөн багш нь сурагчдын тухайн сэдвийн талаарх өмнөх мэдлэгийг идэвхжүүлэх, тохиромжтой олон төрлийн тохиромжтой хэрэглэгдэхүүнээр хангах, сурагчдыг ойлгож, боловсруулж сурахад чиглүүлэх хэрэгтэй. Үүнээс гадна багш нар сурагчдыг ангидаа харилцахыг урамшуулж, тэднийг бодож, ярьж, бичихэд хүргэдэг үйл ажиллагааг ашиглах шаардлагатай. АХИС багш нар сурагчдын ахиц дэвшлийг хэл болон агуулгын аль алинд нь үнэлж, тэдний хоёр талын хөгжлийг дэмжихүйц зөвлөгөөгөөр хангаж байх хэрэгтэй.

Бид өмнөх зөвлөмжид АХИС-н хичээлийн төлөвлөлтөд авч үзсэн зарим санааг баяжуулан сэргээн сануулж байна.

1. Хичээлийн эхэнд хэлний зорилгыг тодорхой болгох

Судлагдахууны суралцахуйн үр дүнгээс гадна хэлний зорилтыг тодорхой болгох, жишээ нь,

- Энэ сэдвээр бид “харьцуулах”, “ангилах” “ийм учраас” зэрэг үгсийг ашиглаж сурна.
- Та бүхэн “өнгөрсөн үе, одоо үе,” гэсэн үгсийг өгүүлбэрт хэрэглэж сурна.

Ингэснээр сурагчийн хэлний хэрэглээ тодорхой болно.

2. Академик үгийн сан дээр анхаарах

Судлагдахууны багшийн хэлний хамгийн чухал дэмжлэг бол академик үгийг тодорхой, зурагтай, ойлгомжтой танилцуулах явдал юм. Ингэхдээ,

- Үг + зураг
- Үг + хөдөлгөөн (TPR)
- Үг + Монгол/Казах тайлбар
- Ханан дээрх үгсийн сан
- Өгүүлбэрийн загвар зэргийг ашиглана.

Шинэ үгсийг хэрхэн сургах вэ?

Сурагчид шинэ үгийг нэг удаа зааснаар шууд хэрэглэх чадвартай болно гэж хүлээх хэрэггүй. Тэдгээр үгсийг олон удаа сонсож, уншиж байж хэлний хэрэглээний идэвхтэй нэг хэсэг болно.

Шинэ үгтэй ажиллахдаа...

- *Шалгах*: Хичээлд ашиглах хэрэглэхүүн дээр ямар шинэ үгс байгааг урьдчилан шалгаарай.
- *Гол үгсийг урьдчилан заах*: Сурагчид зайлшгүй мэдэх шаардлагатай түлхүүр үгсийг л тайлбарлаж өгөөрэй.
- *Үгийн бүтцийг ашиглах*: Үгийн утгыг таамаглахад туслах хэлбэрийг харуулаарай.
 - Жишээ нь: **-сан**⁴ төгсгөл → өнгөрсөн цагийн үйл үг;
 - төгсгөл → үг байх магадлалтай.
- *Орчныг ашиглах*: Үгийн утгыг тухайн өгүүлбэрийн эсвэл эхийн орчноос таамаглахад нь туслаарай.
- *Идэвхтэй даалгавар өгөх*: Шинэ үгсийг зөвхөн унших биш, идэвхтэй хэрэглэхээр (жишээ нь: үгсээр өгүүлбэр зохиох, оюуны зураглал хийх, багийн тоглоом тоглох) даалгавар өгөөрэй.

Сурагчдад үгсийг тогтооход хэрхэн туслах вэ?

Шинэ үгсийг тогтоох нь АХИС хичээлийн хамгийн том сорилтуудын нэг. Үүнийг үр дүнтэй болгохын тулд дараах аргуудыг хэрэглэж болно:

1. Үгсийг дахин давтах хэрэглэх;
 - Өмнөх хичээл дээр сурсан үгсийг дараагийн хичээлд сануулж, дахин хэрэглүүлэх; Жишээ нь: богино асуулт, тоглоом, эсвэл өмнөх үгс орсон шинэ өгүүлбэр зохиох.
2. Үгсийг идэвхтэй даалгавараар хэрэглэх;
 - Шинэ үгсийг зөвхөн уншуулах биш, идэвхтэй хэрэглүүлэх; Жишээ нь:
 - Өгүүлбэр зохиох;
 - Оюуны зураглал хийх;
 - Багаар тоглох.
3. Хувийн үгийн сангийн дэвтэртэй болох
 - Сурагч бүр шинэ үгсийн тэмдэглэл, толь бичиг хөтөлнө.
 - Үг бүрийн хувьд: Үг, Утга, Жишээ өгүүлбэр (уг үгийг хэрхэн хэрэглэхийг харуулсан)

Давуу тал

- Сурагчид үгсийг олон удаа харж, сонсож, хэрэглэснээр тогтоох чадвар нь нэмэгдэнэ.
- Үгийн сангийн дэвтэр нь сурагчдад өөрийн ахиц дэвшлийг харах, давтах боломж олгоно.

3. Зорилтот хэлний өгүүлбэрийн бүтцийн дагуу бичих загварыг заавал өгөх

Судлагдахууны багш хэлний багш шиг дүрэм заах албагүй. Гол нь сурагчийг академик өгүүлбэрээр ярих, бичихэд чиглүүлэх нь чухал. Жишээ, *Харьцуулах*

- ___ болон ___ нь хоорондоо ялгаатай байна.
- ___ болон ___ нь хоорондоо ___ -раа ялгаатай байна.
- ___ нь ___ -нээс бага (жижиг, олон, цөөн) байна.

Шалтгаан–үр дагавар

-
-

Эдгээрийг ханан дээр байрлуулбал хүүхэд хичээл бүрт хэрэглэнэ.

4. Богино, энгийн, тодорхой хэллэг ашиглах

АХИС-д багшийн яриа чухал үүрэгтэй. Тиймээс багш:

- 1 өгүүлбэр = 1 санааг илэрхийлэх;
- Утгагүй урт тайлбар, олон нөхцөл байдал бүхий өгүүлбэрээс зайлсхийх;
- Зураг, дүрс, хөдөлгөөн ашиглах;
- Хүнд, хэцүү үгийг энгийн, хэрэглэдэг үгээр солих;

- Шинэ мэдээллийг 2–3 дахин давтах хэрэгтэй.

Жишээ нь:

..... + зураг
..... + хөдөлгөөн

5. Эх хэл ба зорилтот хэлийг уялдуулах

Монгол-казах хос хэлт орчинд хэлийг уялдуулж, шилжүүлэх шаардлагатай. Иймээс багш:

- Ойлголтыг эх хэлээр баталгаажуулж болно.
- Шинэ үгийг 2 хэлээр холбож өгнө.
- Бүлгийн ажил дээр эх хэлээр нь ярилцуулж болно.
- Гэхдээ үр дүнг (танилцуулга, постер, бичвэр) нь зорилтот хэлээр хийлгэнэ. Эдгээр нь АХИС-д үр дүнтэй хэлний дэмжлэг болно.

Судлагдахууны багш нар хэлний хэрэглээний хувьд дээр дурдсан зүйлсээс гадна *хүүхдийн хэлний түвшинд тохируулсан ялгаатай үйл ажиллагаа төлөвлөх, зорилтот хэлний яриа ба бичгийн үйл ажиллагааг төлөвлөх, зураг, бүдүүвч, диаграмм, он цагийн шугам зэрэг хэрэгслийг өргөн ашиглах, задлан шинжлэх, үнэлэх, дүгнэх* зэрэг танин мэдэхүйн дээд түвшнийг хөгжүүлэх зэрэгт анхаарах хэрэгтэй байдаг.

Мөн судлагдахууны багш өөрийн хэлний чанарт анхаарах хэрэгтэй. Тухайлбал, багшийн:

- тод дуудлага
- стандарт үг хэллэг
- тохиромжтой хурд
- ойлгомжтой асуулт
- цахим эх сурвалж ашиглах зэрэг нь сурагчдын хэлний орчныг маш хүчтэй дэмждэг.

АХИС-н хичээл ба сайн туршлага

Баян-Өлгий аймгийн багш нарын туршлагаас - Ээлжит хичээлийн төлөвлөлт

Судлагдахуун: Технологи

Анги: 5

Сэдэв: Байгалийн материал ашиглан бүтээл хийх

Хугацаа: 1 цаг

Сургалтын хэл: Казах

Зорилтот хэл: Монгол

Хэлний харьцаа: 85:15 (Х1-85%, Х2-15%)

Суралцахуйн зорилт: **5.2e.** Байгалийн материал (хушга самар, чулуу) ашиглан бүтээл хийх.

Хичээлийн зорилт:

- Сурагч бүр хушганы самар, чулуу зэрэг жижиг зүйлүүдийг түүж цуглуулах;
- Хушганы самар, жижиг чулуу, баримлын шавар ашиглан өнгө ялган будах;
- Бүтээл хийх;
- Бүтээлээ танилцуулах;









Хичээлийн арга: Символды тилек, «Тілші»









Хичээлийн зорилго:		
1	Агуулгын:	<ul style="list-style-type: none"> - Байгалийн материалын тухай ойлголт (хушга самар, чулуу, шавар, усан будаг) - Байгалийн материал ашиглан бүтээл хийх арга - Аюулгүй ажиллагааны дүрэм - Бүтээлээ танилцуулах, тайлбарлах
2	Нийгэмших (харилцаа):	Сурагчид багаар ажиллах, бие биеэ сонсож харилцан ярилцах, санал бодлоо солилцох, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх, хамтран ажиллахад суралцана.
3	Хэлзүй:	<ul style="list-style-type: none"> - Хичээлийн бататгах үе шатыг зорилтот хэл дээр зохион байгуулна. - Агуулгатай холбоотой шинэ үгсийг сурна.
Шинэ нэр томьёо, шинэ үгс:		Байгалийн материал, хушга самар, чулуу, баримлын шавар, усан будаг
Үйл ажиллагаа:		<ul style="list-style-type: none"> - Багт хуваагдах; - Байгалийн материал цуглуулах; - Бүтээл урлах (жигжиг цох хийх); - Бүтээлээ танилцуулж тайлбарлах; - Оньсого таах, дүрс эвлүүлэх; - Сэтгэгдлээ солилцох;
Хэлний бүтэц:		<ol style="list-style-type: none"> 1. Түлхүүр үгс: <i>байгалийн материал, хушга самар, чулуу, баримлын шавар, усан будаг.</i> 2. Үйл үгс: <i>ашиглах, урлах, тайлбарлах, танилцуулах.</i> 3. Хэлний загвар: <ul style="list-style-type: none"> “Би ... ашиглан цох хийсэн.” “Манай баг ... материалаар бүтээл урласан.” “Цохыг хэрхэн хийсэн бэ? ...”
Хэрэглэгдэхүүн:		Байгалийн материал (хушга самар, жигжиг чулуу), баримлын шавар, усан будаг, багс, хайч, цавуу, бичлэг үзүүлэх төхөөрөмж, зураг (санаа авах загвар)




Үнэлгээ: Явцын үнэлгээ

Хичээлийн явц:

Үе шат	Хугацаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
Зохион байгуулах	4 мин Х1	<p>Алхам 1.</p> <ul style="list-style-type: none"> - Баг болж хуваагдана. (Сурагчид хайрцгаас материал сугалж, ижил материал авсан сурагчид 1 баг болон сууна) - Аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцана. <div style="border: 1px solid black; padding: 5px; margin-top: 10px;"> <p>Қауіпсіздік ережесі:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сұйық затты төгіп алмау; 2. Бояуды үрлемеу; 3. Демін татпау; 4. Қайшыны дұрыс беру. </div>	<p>Алхам 1.</p> <ul style="list-style-type: none"> - Багт хуваах (Сурагчид хайрцгаас материал сугалж, ижил материал авсан сурагчдыг 1 баг болгон суулгах) - Аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцах. <div style="border: 1px solid black; padding: 5px; margin-top: 10px;"> <p>Қауіпсіздік ережесі:</p> <ol style="list-style-type: none"> 5. Сұйық затты төгіп алмау; 6. Бояуды үрлемеу; 7. Демін татпау; 8. Қайшыны дұрыс беру. </div>

		<ul style="list-style-type: none"> - Хичээлийн онцлогтой танилцана. (Хичээл хоёр хэлээр явагдана)  <ul style="list-style-type: none"> - Хичээлийн дэгээ танилцуулна. <p>Сабақ ережесі: \Х1\</p>  <ul style="list-style-type: none"> - Зургийн дагуу ерөөлийн үг хэлнэ. 	<ul style="list-style-type: none"> - Хичээлийн онцлогийг танилцуулах. (Хичээл хоёр хэл дээр явагдах бөгөөд домборын зураг гарахад казах хэлээр, морин хуурын зураг гарахад монгол хэл буюу зорилтот хэлээр ярих болно)  <ul style="list-style-type: none"> - Хичээлийн дэгээ танилцуулах. <p>Сабақ ережесі: \Х1\</p>  <ul style="list-style-type: none"> - Зургийн дагуу ерөөлийн үг хэлэх. 
<p>Сэдэлжүүлэх</p>	<p>6 мин</p>	<p>Алхам 2.</p> <ul style="list-style-type: none"> - Дүрс эвлүүлж, хичээлийн сэдвийг гаргана. (Хайчилсан дүрсийг эвлүүлэн цохны дүрс үүсгэн хичээлийн сэдвийг гаргана)  <ul style="list-style-type: none"> - Багууд бүтээл хийх материалаа сонгон тухайн материалын нэрээр багаа нэрлэнэ. (Сурагчид оньсого, зурагт таавар тааж, үеэр үг бүтээж, түрүүлж хариулсан баг нэршлээ аван багт хуваагдах ба тухайн материалаар бүтээлээ хийнэ) 	<p>Алхам 2.</p> <ul style="list-style-type: none"> - Хайчилсан дүрсийг эвлүүлэн хичээлийн сэдэв гаргах (Хайчилсан дүрсийг эвлүүлэн цохны дүрс үүсгэн хичээлийн сэдвийг гаргах)  <ul style="list-style-type: none"> - Багууд ямар материал ашиглан бүтээл хийхээ сонгон тухайн материалаар багаа нэрлэх. (Сурагчдаар оньсого, зурагт таавар таалган, үеэр үг бүтээлгэн түрүүлж хариулсан баг нэршлээ аван багт хуваагдах ба тухайн материалаар бүтээлээ хийх)

		<p style="text-align: center;">Ермексаз</p> <p style="text-align: center;">  + ''' + саз </p> <p style="text-align: center;">Өңді қағаз</p> <p style="text-align: center;"> -ді -ғаз </p> <p style="text-align: center;"> қа өң </p> <p style="text-align: center;">Хушга (самар)</p> <p style="text-align: center;">  </p> <p style="text-align: center;">Чулуу</p> <p style="text-align: center;">  </p> <div style="border: 1px solid black; padding: 5px; margin-top: 10px;"> <p>Жұмбақ шешеміз:</p> <p>Пайда болғанда адам баласы, Қандай құралды алғаш қолданды?</p> <p>Сырты тас, іші қуыс бөлек-бөлек, Базардан оны сатып алса керек. Алған жанға тағамдық пайдасы бар, Шешіп бер жұмбағымды, түсіне алсаң.</p> </div>	<p style="text-align: center;">Ермексаз</p> <p style="text-align: center;">  + ''' + саз </p> <p style="text-align: center;">Өңді қағаз</p> <p style="text-align: center;"> -ді -ғаз </p> <p style="text-align: center;"> қа өң </p> <p style="text-align: center;">Хушга (самар)</p> <p style="text-align: center;">  </p> <p style="text-align: center;">Чулуу</p> <p style="text-align: center;">  </p> <div style="border: 1px solid black; padding: 5px; margin-top: 10px;"> <p>Жұмбақ шешеміз:</p> <p>Пайда болғанда адам баласы, Қандай құралды алғаш қолданды?</p> <p>Сырты тас, іші қуыс бөлек-бөлек, Базардан оны сатып алса керек. Алған жанға тағамдық пайдасы бар, Шешіп бер жұмбағымды, түсіне алсаң.</p> </div>
<p>Шинэ мэдлэг олгох</p>	<p>5 мин Х1</p>	<p>Алхам 3.</p> <ul style="list-style-type: none"> - Хичээлийн зорилго зорилттой танилцана. - Бичлэг үзнэ. - Нэмэлт мэдээлэлтэй танилцана. - Онъсого тааж, ямар материалаар бүтээл хийхээ тодорхойлно. <div style="display: flex; align-items: flex-start; margin-top: 10px;">  <div style="margin-left: 10px; font-size: 0.8em;"> <p>Қанқазы туралы. Мультфильм /Боякы коровка/ Құрастырған: Еспенбетова Ақсира 138 көлем - 2 үлкен аяқ Модель А.С.</p> <p>Балаларға Мультфильмдер арқылы қанқазы туралы мәлімет беру. Жалпаққада Мультфильмдер арқылы беріледі.</p> </div> </div> <div style="margin-top: 10px;"> <p>Кей елдерде бақыт шақыратын жандық деп атайды екен.</p> <p>Орыс ұлты киелі жандық деп қастерлеп өлтірмейді.</p> <p>Бір қанқазы өз өмірінде 4000 –ға жуық көнені жоя алады.</p> </div>	<p>Алхам 3.</p> <ul style="list-style-type: none"> - Хичээлийн зорилго зорилтоо танилцуулах; - Дүрс эвлүүлж, хичээлийн сэдвийг гаргах; - Бичлэг үзүүлэх; - Нэмэлт мэдээлэл олгох; - Онъсого тааж, ямар материалаар бүтээл хийхээ гаргах. <div style="display: flex; align-items: flex-start; margin-top: 10px;">  <div style="margin-left: 10px; font-size: 0.8em;"> <p>Қанқазы туралы. Мультфильм /Боякы коровка/ Құрастырған: Еспенбетова Ақсира 138 көлем - 2 үлкен аяқ Модель А.С.</p> <p>Балаларға Мультфильмдер арқылы қанқазы туралы мәлімет беру. Жалпаққада Мультфильмдер арқылы беріледі.</p> </div> </div> <div style="margin-top: 10px;"> <p>Кей елдерде бақыт шақыратын жандық деп атайды екен.</p> <p>Орыс ұлты киелі жандық деп қастерлеп өлтірмейді.</p> <p>Бір қанқазы өз өмірінде 4000 –ға жуық көнені жоя алады.</p> </div>

	X2 2 мин	<ul style="list-style-type: none"> - Түлхүүр үг (X2) - Түлхүүр үгийг зөв уншина. <p>Байгалийн материал - табиги өнім, зат Хушга самар - жаңгақ Чулуу - тас Шүрэн цох - қанқызы Баримлын шавар - ермексаз Усан будаг - су бояу</p>	<p>Ашиглах - пайдалану, қолдану Байгалийн материал - табиги өнім, зат Хушга самар - жаңгақ Чулуу - тас Шүрэн цох - қанқызы Баримлын шавар - ермексаз Усан будаг - су бояу</p>
Бүтээл хийх	X1 15 мин	<p>Алхам 4</p> <ul style="list-style-type: none"> - Багууд өөрт оногдсон материалаар бүтээлээ урлана. - Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална. 	<p>Алхам 4</p> <ul style="list-style-type: none"> - Багаар ажиллах. “Миний хөөрхөн Цох” сэдэвтэй бүтээл хийх; - Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах. 
Бататгах	X2 4 мин	<p>Алхам 5</p> <ul style="list-style-type: none"> - Бүтээлээ яаж хийсэн тухай нэг нэгэндээ хэлж өгч танилцуулна. - Шилдэг бүтээлээ бусад багт яаж хийснээ тайлбарлана. 	<p>Алхам 5</p> <ul style="list-style-type: none"> - Загварчилж хийсэн бүтээлээ тайлбарлах; - Яаж, юугаар бүтээснээ тайлбарлах.
Үнэлэх	3 мин X1	<ul style="list-style-type: none"> - Нэг сурагч сурвалжлагч болж, сэтгэгдлээ асууна. - Оператор зураг авна. - Сурагчид өөрсдийн сэтгэгдлээ чөлөөтэй илэрхийлнэ. 	<ul style="list-style-type: none"> - Өнөөдрийн хичээлээс авсан сэтгэгдлээ хэлнэ үү? - Та нар цохыг ямар материал ашиглаж бүтээсэн бэ? - Цох ямар ач тустай вэ? - Өнөөдрийн хичээл юугаараа сонирхолтой байсан бэ?
Гэрийн даалгавар	1мин X1	 	<p>Байгалийн материал ашиглаж бүтээл хийж ирэх.</p>

Дасгал 4. “Миний хөөрхөн Цох” сэдэвтэй бүтээл хийх

Алхам 3

Дасгал 5. Зургаас санаа авч бүтээл хийгээрэй.



Дасгал 6. Загварчилж хийсэн бүтээлээ бусад танилцуулж тайлбарлаарай

- Бүтээлээ хэрхэн хийснээ бие биедээ танилцуулах;
- Сурагчид баг дотроос хамгийн шилдгийн шилдэг бүтээлийг шалгаруулах;
- Шилдэг бүтээлээ бусад багт яаж бүтээснээ тайлбарлана.

Нэгж хичээлийн төлөвлөлт – Математик - АНУ

Хөтөлбөрийн ачаалал: 50/50.

Сургалтын хэл: англи, испани.

Анхны (бага) боловсролын хэл: бүх сурагчид англи, испани хэлээр зэрэг суралцдаг.

Угсаатны дүр зураг (хөрөг): сурагчдын олонх нь (71%) Бүгд Найрамдах Доминикан Улс, Пуэрто Рико, Мексик, Эквадор, Эль Сальвадор, Гондурас, Колумб, Латин Америк, Карибын тэнгисийн орнууд болон бусад орнуудаас гаралтай латин америк гэр бүлийн хүүхдүүд байна, харин 27 хувь нь Карибын тэнгисийн англи хэлтнүүд болох афро америк гаралтай юм. Үлдсэн 2 хувийг ази, европчууд бүрдүүлдэг.

Анги: Гурав.

Судлагдахуун: Математик

Судлах хугацаа: 5 хичээл.

Хичээл заах хэл (хэлнүүд): англи, испани

Хичээлийн сэдэв: «Геометрийн ерөнхий мэдлэгийг гүнзгийрүүлэхэд хятад танграмм (оригами)-ыг хэрэглэх нь»

Агуулгын стандарт: Математикийн багш нарын Төрийн зөвлөлөөс боловсруулсан 3-5 дугаар ангийн геометрийн хичээлийн үндэсний стандарт.

Хэлний стандарт: Англи хэлний багш нарын Төрийн зөвлөл болон Олон улсын уншлагын нийгэмлэгээс боловсруулсан англи хэлний стандартууд.

Стандарт 4. Сурагчид янз бүрийн орчинтой үр дүнтэй харилцаж, өөр өөрийн тавьсан зорилгод хүрэхийн тулд ярианы, бичгийн болон биеийн харилцааны хэлийг (жишээ нь: конвенци, загвар, үгсийн сан) хэрэглэнэ.

Стандарт 12. Сурагчид зорилгодоо хүрэхийн тулд ярианы, бичгийн болон биеийн харилцааны хэлийг хэрэглэнэ (тухайлбал, сургалт явуулах, баяр баясгалан, итгэл үнэмшил, мэдээлэл солилцох).

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан сурагчдын хувьд хоёрдогч хэл болох англи хэлний стандарт

Зорилго 2. Хичээлийг судлахад (сургалтын хэл) хэрэглэгдэх хэл.

Стандарт 1. Сурагчид хичээл дээр харилцах хэлийг ашиглах болно.

Гол асуултууд

- Танграмм гэж юу вэ?
- Ерөнхий дүрсүүдийн хоорондох геометр харьцаа гэж юу вэ?
- Дүрсүүд хөдөлж, эргэлдэж байх үед юу болдог вэ?
- Танграмм дүрсүүдийг ашиглан ямар төслүүдийг хийж болох вэ?
- Хэд хэдэн танграмыг хослуулан нийлүүлэх замаар ямар шинэ дүрсүүдийг зохиож болох вэ?

Үндсэн (гол) ойлголтууд

- Дүрсүүдийг зөөж, шилжүүлэх эсвэл эргүүлэх боломжтой.
- Танграмын хэсгүүдийг нэгтгэж стандарт геометр дүрс эсвэл уран сайхны дүрсийг бүтээж болно.
- Геометрийн ойлголт нь уран сайхны сэтгэлгээг илэрхийлэхэд чухал ач холбогдолтой.

Хэлний ур чадвар

Сэдэвтэй холбоотой толь бичиг

- Tangram/Tan (танграм/тан, оригами)
- Triangle, square, rectangle, parallelogram, trapezoid (гурвалжин, квадрат, тэгш өнцөгт, параллелограмм, трапеци)
- Right angle (зөв өнцөг)
- Flip, slide, rotate (солих, шилжүүлэх, эргүүлэх, хөдөлгөх)
- Small, medium, large (бага, дунд, том)
- Fold, cut (нугалах, тайрах, зүсэх)
- Pattern (загвар)
- Clockwise, counterclockwise (цагийн зүүний дагуу, цагийн зүүний эсрэг)
- Congruent, similar (зохих, тохирох, ижил төстэй)

Унших

- Танграмын түүхийг унших

Сонсох

- Аман зааврыг ойлгох;
- Асуулт, хариултыг хамт боловсруулах;
- Тусламж, мэдээлэл авах хүсэлтээ илэрхийлэх.

Ярих

- Хэрэв шаардлагатай бол, захирах хүсэх төлөвт байгаа үйл үгийг хэрэглэх, нэмэлт тайлбар өгөх, тодорхой зааврыг томъёолох.
- Нэмэлт тодруулга хүсэх тухай хүсэлтээ илэрхийлэх.
- Анги бүлгээрээ, багаараа, эсвэл хосоороо ярилцлага, хэлэлцүүлэгт оролцох.

Бичих

- Үлгэр зохиох

Багшийн анхааралд:

Сургалтын төлөвлөгөө нь судлагдахууны хэл, анги, хичээлийн онцлогоос шалтгаалж өөрчлөгдөж болно. Мөн хос хэлээр боловсрол олгох янз бүрийн стратеги, бүрэлдэхүүнийг ашиглах туршлагаасаа тусгана.

Багш нар өгөгдсөн сургалтын төлөвлөгөөтэй танилцаж, өөрсдийнхөө багшлах үйл ажиллагаанд хэрэгжүүлж болох хэсгээ сонгохын хамт өөрийн гэсэн ямар нэгэн заах аргатай болохыг бодохыг, мөн боловсруулагчдын зөвлөмжийг ашиглахыг, эсвэл түүнийг өөрийн зааж буй судлагдахуунд, ангийнхаа сурагчдын хэлний цогцолбор, бэлтгэлийн түвшинд тохируулж хялбаршуулан хэрэглэж болохыг зөвлөж байна.

Англи хэл дээрх нийтлэл бүрэн эхээр:

https://www.brown.edu/academics/education-alliance/sites/brown.../toolkit_all.pdf

Эх сурвалж: Диалоги, №17

Нэгж хичээлийн төлөвлөлт - Дэлхийн түүх - Монгол

Бүлэг сэдэв	Монголын эзэнт гүрний дараах Монгол ба дэлхий дахин (XV-XVIII зууны дунд үе)
Сурагчдын хэлний дүр зураг:	6-р ангиасаа 3 дахь жилдээ англи хэлийг гүнзгийрүүлэн судалж байна. Англи хэлний хөтөлбөрийн түвшнийг тавих
Анги	8
Судлагдахуун	Түүх
Сургалтын хэл	Хэл 1: Монгол хэл Хэл 2: Англи хэл
Сургалтын хөтөлбөр (Агуулга)	Түүхийн боловсролын үндэсний хөтөлбөр

Судлагдахууны зорилт	Ээлжит хичээл	Төлөвлөсөн цаг	Хэлний зорилт	Хэлний харьцаа/ жин	Түвшин
8.2б. Дэлхийн түүхэн дэх газар зүйн их нээлт, колоничлолын талаар мэдэх, эдгээр үйл явдлын түүхэн үүрэг, үр дагаврыг илрүүлэх	Газарзүйн их нээлт	40 мин			
	Колоничлол	40 мин	-		
8.2в. Шашны шинэтгэх хөдөлгөөн, сэргэн мандалт, соён гэгээрлийн үзэл санаатай танилцаж, тэр үеийн түүхэн зүтгэлтний үйл хэргийг дүгнэх, дэлхийн түүхэнд оруулсан хувь нэмрийг тодорхойлох	Шашны шинэтгэлийн хөдөлгөөн	40 мин	- Унших - ??? - Ярих - ??? - Бичих - Сонсох	Хэл 1 60% Хэл 2 40%	
	Сэргэн мандалт	40 мин	- Шинэ үг - Өгүүлбэр зүй		
	Соён гэгээрлийн хөдөлгөөн	40 мин			
Нийт	5	200 минут			

Ээлжит хичээлийн төлөвлөлт

Хичээлийн сэдэв	Шашны шинэтгэл
Суралцахуйн зорилт Хичээлийн зорилго	Шашны шинэтгэлийн шалтгаан, ач холбогдлыг холбогдох сурвалжуудыг ашиглан тодорхойлох
Хичээлийн зорилт	<ul style="list-style-type: none"> ○ Тухайн үеийн нийгмийн байдлыг тодорхойлох ○ Тухайн үйл явдлын шалтгаан, үр дагаврыг үндэслэлтэй тайлбарлах (сурвалжийн утгыг тайлах), тодорхойлох ○ Мэдээлэлд анализ хийх, мэдээллийн утгыг тайлбарлах
Суралцагчдын хэлний дүр зураг	6-р ангиасаа англи хэлийг гүнзгийрүүлэн судалсан
Хэлний зорилт	<ul style="list-style-type: none"> ○ Унших -????? ○ Ярих -?????? ○ Сонсох ○ Шинэ үг сурах ○ Бичих - өгүүлбэр зүй
Түлхүүр үг	Нэр томьёо: Индульгенц, Реформац, Инквизия, Тэрс үзэлтэн, шалтгаан, ач холбогдол, түүхэн хүмүүс Ашиглах үйл үгс:

Хичээл заах хэл:	Хэл 1: Монгол хэл Хэл 2: Англи хэл
Судлах цаг	40 минут
Судлах арга	Сурвалжийг тайлбарлах, шинжлэх
Хэрэглэгдэхүүн	Ц.Гантулга нар. “Түүх VIII”. Улаанбаатар, 2015, ажлын хуудас, мультимедиа үзүүлэн материал
Үнэлгээ	Түүхэн сурвалжид анализ хийх, ажлын хуудас дээр ажилласан байдал


Хичээлийн үе шат		Суралцахуйн үйл ажиллагаа	Хэл	Хэрэглэгдэхүүн
Зохион байгуулалт	2 мин	- Мэндчилэх; - Хичээлийн сэдвийг англи, монголоор бичих; - Хичээл зохион байгуулалтыг танилцуулах;	Монгол	Дэлгэц, проектор, самбар
Сэдэлжүүлэх	3 мин	- Үгсийг зөв дараалалд оруулж, түлхүүр үгсийг бүтээх; - Түлхүүр үгсийн орчуулгыг бичиж тэмдэглэж авна.	Англи, Монгол	Ажлын хуудас-1
Агуулгыг танилцуулах	8 мин	Багш түлхүүр үгсийг ашиглан хичээлийн агуулгыг танилцуулна.	Монгол	Проектор, дэлгэц, ажлын хуудас
Сурвалжтай ажиллах	15 мин	1. Сурагчдыг багт хуваана (26 сурагч/ 6 баг). 1-4 дугаарлана. 2. Багийн гишүүд ялгаатай эх сурвалжтай танилцана. Англи хэл дээр – 3 минут. Нэмэлт: Эх дээр ажиллахдаа түлхүүр үгийн доогуур зурах, үйл үгийн хувирлыг таних, тэмдэглэж авах зэрэг байж болно. 3. Уншсанаа бусдадаа тайлбарлаж, мэдлэгээ нэгтгэнэ. Монгол хэл дээр – 5 минут 4. Багшийн асуултад багаараа хэлэлцэж хариулж бичнэ (цагаан цаас, маркер тараана). Англи хэл дээр - 8 минут Нэмэлт: Асуултад хариулах өгүүлбэрийн загварыг урьдчилж өгч болно.	Англи Монгол	Ажлын хуудас 2 (Унших эх 1-4) Ажлын хуудас 3 (чиглүүлсэн асуултууд) А3 цаас маркер
Үр дүнгээ нэгтгэж, танилцуулах	12 мин	- Багш багуудын хариултыг агуулгын хувьд чиглүүлнэ. - Өгүүлбэр зүй, үг сонголтыг (англи) хянаана. - Зөвлөгөө өгнө, багууд дээр очиж сонсоно. - Багууд ажлын хуудсаа самбарт тогтооно. - Багш 2 багийг нэрлэж, хариултыг танилцуулна. – Англи хэл дээр	Англи Монгол	
Үнэлгээ	5 мин	- Quiz онлайнаар авах/ 6 асуулттай Quiz боловсруулж <i>socratic.com</i> хуудсаар шууд авах, хариултыг шууд харж ярилцах	Англи Монгол	Ажлын хуудас 4

Ажлын хуудас-1 – англи, монгол хэл


Anagram	Correct - Keywords	Synonyms
Eli Ringo		Church, morality, prayer, spirituality
fori mat Nero		Renewal, transformation, reorganization
Delcine gnu		Уучлал, нүгэл хилэнцийг өршөөх
Саар тан ван		Monk, priest
Үг нэл		Sin, error, fault, misdeed

Ажлын хуудас/сурвалж – 2 – англи хэл


Эх сурвалж 1

 <p>Martin Luther Painting by Lucas Cranach the Elder, 1530</p> <p>martin luther 95 theses - Bing images</p>	<p>Marthin Luther – Biograophy</p> <p>According to his father’s wish Martin Luther enrolled at the University of Erfurt in 1501, the premiere university in Germany at the time. There, he studied the typical curriculum of the day: arithmetic, astronomy, geometry and philosophy and continued for Master’s degree. In July of 1505, Luther got caught in a violent thunderstorm, in which a bolt of lightning nearly struck him down. He considered the incident a sign from God and vowed to become a monk if he survived the storm.</p> <p>After surviving the storm, Luther began to live the rigorous life of a monk but did not abandon his studies. In 1510–1511, he took a break from his education to serve as a representative in Rome for the German Augustinian monasteries. In 1512, Luther received his doctorate and became a professor of biblical studies.</p> <p>Martin Luther and the 95 Theses - Summary, Origins & Video - HISTORY</p>
---	--

Эх сурвалж 2

 <p>95-</p> <p>Theses.jpg (338x450) (ucalgary.ca)</p>	<p>Marthin Luther – 95 Theses</p> <p>Luther vigorously objected to the corrupt practice of selling indulgences. Acting on this belief, he wrote “The 95 Theses,” a list of questions for debate. Popular legend has it that on October 31, 1517 Luther defiantly nailed a copy of his 95 Theses to the door of the Wittenberg Castle church. The 95 Theses would later become the foundation of the Protestant Reformation.</p> <p>The first two of the theses contained Luther’s central idea, that God intended believers to seek repentance and that faith alone would lead to salvation.</p> <p>Martin Luther translated the Bible into German language.</p> <p>Martin Luther and the 95 Theses - Summary, Origins & Video - HISTORY</p>
---	---

Эх сурвалж 3

 <p>Johann Tetzel - Wikipedia</p>	<p>Johann Tetzel – Biography</p> <p>Johann Tetzel was born in the Holy Roman Empire in 1465. He joined the Church and became a priest. In 1502, Cardinal <i>Giovanni di Lorenzo</i> commissioned Tetzel to preach about <i>indulgences</i>, which he did for the remainder of his life.</p> <p>In 1516, Johann Tetzel, was sent to Germany by the Roman Catholic Church to sell <i>indulgences</i> to raise money in order to rebuild St. Peter's Basilica in Rome.</p> <p>Martin Luther criticized his preaching about indulgences, which sparked the start of the Reformation.</p> <p>Johann Tetzel - Wikipedia</p>
--	--

Эх сурвалж 4



[St.Peter's Basilica, Rome](#)

Johann Tetzel – selling Indulgences

Jochen Tetzel claimed to be collecting indulgences for the ongoing restoration of **Saint Peter' Basilica**. Scandal erupted when it came to light that Tetzel was selling forgiveness for sins that had not been committed yet.

Tetzel over exaggerated the Catholic Church's position on indulgences, suggesting that not only could one pay the Church to erase their dead relative's sins (releasing them to heaven), but one could also pay to remove their own future sins. This was not Church teaching, but more Tetzel's own belief system.

Martin Luther took issue with Tetzel's selling of indulgences and wrote his **95 Theses** in response in part to Tetzel's actions. This led to the **Reformation**.

[Martin Luther and the 95 Theses - Summary, Origins & Video - HISTORY](#)

Ажлын хуудас 3 – монгол/ англи

Асуулт 1:

Шашны шинэтгэл зайлшгүй шаардлагатай болсон учир шалтгаан юу вэ?
Why was the reformation necessary?

Асуулт 2:

Шашны шинэтгэлийн үр дагавар юу вэ?
What are the consequences of the reformation?

Асуулт 3:

.....

Ажлын хуудас 4 – англи.

Quiz-зөв 1 хариулттай. Англи, монгол хэлээр. Socrative программаар шууд харж, хамгийн их алдсан 2 асуултыг ярилцана.

№	Асуулт	Хариулт	Тайлбар
1			
2			
3			
4			
5			

АХИС-г дэмжих шаардлагатай хэрэгслийн жишээ

а) Аман танилцуулгын үнэлгээний шалгуур

Нэр: Анги:

Түвшин Тодорхойлогчид	Онц сайн 4	Сайн 3	Дунд 2	Дунджаас доогуур 1
Агуулга	Агуулга бүрэн үнэн зөв. Сурагч сэдвээ гүнзгий ойлгосон нь харагдана.	Агуулга ихэвчлэн үнэн зөв, сэдвээс гажаагүй. Сурагч сэдвээ сайн ойлгосон.	Зарим мэдээлэл үнэн зөв боловч, хэсэг нь сэдвээс гажсан. Сурагч сэдвээ тодорхой хэмжээнд ойлгосон.	Сурагч сэдвээ бодитоор ойлгоогүй; зарим мэдээлэл нь холбогдолгүй.
Хэл (зөв бичих дүрэм)	Хэл найруулгын алдаа маш цөөн. Яриа нь бараг төрөлх хэлээр ярьж байгаа мэт сонсогдоно.	Хэл найруулгын хэд хэдэн алдаа байгаа ч танилцуулгад саад болоогүй.	Хэл найруулгын алдаа заримдаа танилцуулгыг ойлгомжгүй болгож, саад учруулдаг.	Хэл найруулгын алдаа харилцаанд саад учруулж, танилцуулгыг ойлгоход хүндрэлтэй болгож байна.
Танилцуулах ур чадвар ба туслах хэрэгсэл	Сонсогчдын анхаарлыг татсан. Харааны туслах хэрэгслийг олон янзаар, үр дүнтэй ашигласан. Яриа нь тод, ойлгомжтой, итгэлтэй.	Сонирхолтой танилцуулга. Харааны туслах хэрэгслийг олон янзаар үр дүнтэй ашигласан. Ихэнх хугацаанд тод, итгэлтэй ярьсан.	Заримдаа сонирхолтой. Харааны туслах хэрэгслийг хэсэгчлэн ашигласан. Яриа нь заримдаа ойлгомжгүй. Нүдний харц, нүүрний хувирал байгаа.	Мэдээллийг ойлгоход бэрх; харааны туслах хэрэгсэл маш цөөн; яриа ихэвчлэн ойлгомжгүй, сонсогчдын анхаарал байнга сарнидаг.
Уялдаа холбоо ба зохион байгуулалт	Гол санааг тодорхой илэрхийлсэн; жишээнүүд холбогдолтой; мэдээлэл логик дараалалтай; дүгнэлт ойлгомжтой, шилжилтүүд жигд.	Мэдээлэл ихэвчлэн логик дараалалтай; гол санаа, дүгнэлт байгаа; шилжилт заримдаа жигд бус.	Санаа, ойлголтууд сул холбогдсон; шилжилт дутмаг; гол санаа, дүгнэлт бүдэг.	Танилцуулга уялдаа холбоогүй; мэдээллийн дараалалд логик холбоо байхгүй; гол санаа тодорхойгүй, дүгнэлт, шилжилт бараг байхгүй.
Бүтээлч байдал	Танилцуулга нь маш бүтээлч; агуулга нь ойлгомжтой; сонсогчдын анхаарлыг татахын тулд гэнэтийн элемент ашигласан.	Зарим бүтээлч байдал ажиглагдсан; материал, танилцуулах арга хэлбэр нь олон янз.	Танилцуулга нь нэг талыг барьсан, нэгэн хэвийн.	Танилцуулга давтагдсан, бүтээлч байдал бараг эсвэл огт байхгүй.

Багийн үүрэг хуваарилалт	Бүх сурагч идэвхтэй, тэгш оролцсон; сурагч бүрийн үүрэг тодорхой бөгөөд үр дүнтэй гүйцэтгэсэн.	Ихэнх сурагч идэвхтэй оролцсон, хариуцлагаа хуваалцсан; үүрэг заримдаа тодорхойгүй эсвэл бүрэн биелээгүй.	Сурагчдын тал нь идэвхтэй оролцсон, хариуцлагаа хуваалцсан; үүрэг тодорхойгүй.	Бүлгийн 1-2 гишүүн ихэнх ажлыг хийсэн; хариуцлага хуваарилагдаагүй, үүрэг тодорхойгүй.
--------------------------	--	---	--	--

b) Ангийн булан/сэтгүүл хийх багийн ажлын зааварчилгаа

Редакцын баг: Редакцын баг дараах үүрэгтэй байна:

- Баг бүрийн үйл ажиллагаа болон сонгосон сэдвийг хянах - ингэснээр нэг сэдэв давтагдахгүй.
- Бүх нийтлэлийг онлайнаар цуглуулах – хугацааг тохирох хэрэгтэй!
- Хэрэв шаардлагатай бол нийтлэлийг сайжруулахын тулд буцааж илгээх;
- Сэтгүүлийн нүүр хуудсыг зохиох, гарчгийг бодож олох;
- Нийтлэлүүдийн дараалал болон байрлалыг тодорхойлох;
- Агуулгын жагсаалт болон хуудасны дугаарыг нэмэх;
- Сэтгүүлийн эхний хуудсанд зориулсан богино оршил редакцын эх бичих;
- Багштай харилцаа холбоотой байж, ахиц дэвшлээ мэдээлж байх.

Бичих багуудын үүрэг:

- Сэдэв сонгох ба тухайн сэдвийг өөр баг сонгоогүй эсэхийг редакцын багтай шалгах;
- Сэдвийнхээ талаар мэдээлэл хайх. Та интернэт, ном, багшийн өгсөн хавтас зэрэг эх сурвалжуудыг ашиглаж болно.
- Хоёр өөр төрлийн нийтлэл төлөвлөх ба багийн гишүүд үүргээ хуваарилах;
- Эдгээр нийтлэлүүд нь тухайн сэдвийн талаарх мэдээлэл агуулж болох ч дараах хэлбэрүүдийг ч бас ашиглаж болно:
 - Ярилцлага
 - Нэг өдрийн тэмдэглэл: ...-ийн амьдралын нэг өдөр
 - Баримтын булан: Та мэдэх үү...?
 - Харьцуулалт
 - Хошин зураг (комик)
 - Асуудлын булан (захидал ба хариулт)
 - Сэдвийн харьцуулалт
- Нийтлэлд тохирох зураг, зураглал нэмэх;
- Нийтлэл бүрт зохиогчийн нэр эсвэл нэрсийг заавал бичих;
- Нийтлэл бүр нь эх зохиол байх ёстой - интернэт эсвэл бусад эх сурвалжаас хуулсан байж болохгүй.

c) Бичгийн ажлыг төлөвлөх аргачлал

Эхийн төрөл	Зорилго	Эхийн бүтэц
Хүүрнэх эх	Цаг хугацааны дарааллаар үйл явдлыг дахин өгүүлэх	Цаг хугацааны шугам
Тайлбарлах эх	Шинж чанарыг дүрслэн тайлбарлах	Аалзны диаграмм
Тодруулах эх	Ямар нэгэн зүйлийг хэрхэн хийхийг заах	Урсгал диаграмм
Ятгах эх	Ямар нэгэн зүйл хэрхэн эсвэл яагаад болдгийг тайлбарлах	Урсгал диаграмм
Загвар эх	Нэг үзэл бодлыг хамгаалан тайлбарлах	Цэгэн цуваа
Мэтгэлцэх/хэлэлцүүлэг эх	Мэдээлэл, тайлбар, маргааныг олон өнцгөөс танилцуулах	Давуу ба сул талын хүснэгт

d) Бичгийн ажлыг төлөвлөх аргачлал

Бичвэрийн загвар – Машины өнгөний ажиглалт

Бидний нэр:

1.
2.

Гарчиг (сонирхолтой гарчиг бичнэ үү):
 сарын өдөр бид дараах зүйлсийг ажигласан:

Ажиглалтаас гарсан үр дүнг дараах байдлаар харуулж байна (энд юу хийх ёстой байсан тухай бичнэ үү):

Манай үр дүн:

Эхлээд бид нийт машиныг тоолсон. Бид дараах зүйлсийг ажигласан (хувь хэмжээний талаар бичнэ үү):

Эдгээр үр дүн нь өнгөний харьцангуй түгээмэл байдлыг харуулж байна. Хамгийн түгээмэл машины өнгө бол: Бидний бодлоор энэ нь дараах шалтгаантай:

Хамгийн түгээмэл бус өнгө бол: Бидний бодлоор энэ нь дараах шалтгаантай:


Бусад	түгээмэл	өнгөнүүд:	
.....	
Хамгийн	сонирхолтой	ажиглалт	бол:
.....
Учир			нь:
.....		

Хамгийн хэцүү байсан зүйл:

.....

e) Бичгийн ажлыг төлөвлөх аргачлал

Газарзүй: Тайлбар – Газар хөдлөлтийн нөлөө



f) Бичгийн ажлыг төлөвлөх аргачлал

Мэдээллийн технологи: ятгалга – хоёр сургуулийн вэбсайтыг харьцуулсан тойм

Сурагчид хоёр сургуулийн вэбсайтыг харьцуулсан тойм бичихийн тулд хүснэгтэд тэмдэглэл хөтөлнө.


Вэбсайтын онцлог шинжүүд	Вэбсайт А	Вэбсайт В	Санал/сэтгэгдэл	Хэрэгтэй үг хэллэг
Өнгөний хэрэглээ			Вэбсайт Х нь өнгийг ... байдлаар ашигладаг.	Илүү, бага, дутуу
Дизайн			Вэбсайт А-ийн дизайн нь ...	харин, гэтэл
Хэрэглэхэд хялбар байдал			Вэбсайт А-г ... хийхэд илүү хялбар	гэвч, гэсэн ч
Зорилтот хэрэглэгчдэд хандсан байдал (эцэг эх, сурагчид, багш нар)			Вэбсайт В нь ...-д илүү сонирхолтой санагдана.	...-ын үүднээс
Графикийн чанар			Вэбсайт В дээр ашигласан графикууд нь ...	мөн, түүнчлэн
Мэдээллийн бүтэц			Вэбсайт А дээрх мэдээлэл нь ...	гэсэн ч, тэгсэн ч
Агуулга (мэдээллийн бүрэн байдал)			Вэбсайт В-д багтсан агуулга нь ...	тиймээс
Эх (зөв бичих дүрэм, найруулга)			Текст нь ...	иймээс, үүний улмаас
Бусад				

ДӨРӨВ. АХИС ба СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ

Боловсролын сайдын 2025 оны А/229 тушаалаар “Хос хэлний сургалтын талаар баримтлах чиглэл”-ийг хэрэгжүүлж, “3-5 дугаар ангид монгол хэлээр заах судлагдахууныг үе шаттай нэмэгдүүлэх, 6-12 дугаар ангид зарим судлагдахууныг хос хэлээр зохион байгуулах” арга хэмжээг сургууль, орон нутгийн удирдлага дэмжлэг үзүүлж ажиллах нь чухал ач холбогдолтой. Энэхүү хэсэгт өмнө дурдсан зөвлөмж 1-ийн зарим хэсэг болон БНКаЗУ-ын Шымкент хотын 110 дугаар сургуулийн туршлагаас оруулав.

Хос хэлний боловсролыг сургалтад нэвтрүүлэн хэрэгжүүлж буй улс орнуудын болон Баян-Өлгий аймгийн III, V сургуулийн туршлагаас үзэхэд, АХИС-г нэвтрүүлэхдээ дараах хүчин зүйлсэд онцгой анхаарах нь чухал болохыг харуулж байна. Тэр нь:

- тухайн сургуулийн хос хэлт сургалтын бодлого, төлөвлөлт,
- эцэг эх, сурагч багш болон мэргэжилтнүүдийн үүрэг, оролцоо,
- сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалт, хүрэлцээ,
- багшийн хөгжил, багшид үзүүлэх дэмжлэг туслалцаа,
- хос хэлт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр зэрэг болно.



Эдгээр хүчин зүйлсийг бүрэн хэрэгжүүлэхийг гол зорилго болгон ажиллахын зэрэгцээ АХИС-н сургалтын орчныг бүрдүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйл болох багшийн хөгжлийг хангах, тэднийг ажлын байранд нь хөгжүүлэх, хичээлийн төлөвлөлт хийх, нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах (толь бичиг, ажлын хуудас) зэрэг ажлыг нэн тэргүүнд тавьдаг байна. Тухайлбал, АХИС-г туршин нэвтрүүлсэн сургуулиудын үйл ажиллагаанаас харахад дараах хүрээнд ажилласан туршлага байна. Үүнд:

- Сургуулийн хос хэлт сургалтын бодлого/чиглэл-зорилго, зорилтыг тодорхойлох;
- Хос хэлт хичээл/сургалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- Удирдлага, зохион байгуулалтаар хангах, дэмжлэг, үнэлгээ, мониторинг хийх зэргийг тодорхой тусгаж, төлөвлөсөн байх.

Сургуулийн хос хэлт сургалтын бодлого чиглэлийг тодорхойлох, талуудын оролцоо

Бага боловсролыг эх хэл дээр нь эзэмшүүлж буй ЕБС-ийн удирдлага нь багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагч зэрэг сургуулийн олон нийтийн оролцоотойгоор, орон нутгийн төр захиргаа, боловсролын удирдах болон мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр сургалтын хэлний бодлого, чиглэлээ боловсруулж хэрэгжүүлдэг. Энэхүү бодлого чиглэл нь талуудын ойлголцол, дэмжлэг, оролцоонд тулгуурласан тааламжтай, аюулгүй нөхцөл байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн байхад анхаарна. Ялангуяа, эцэг эхийн оролцоог хангах нь хүүхдийн сурах үйл явцад ихээхэн ач тустайг анхаарч, тэдэнд зориулсан дэмжих болон хамтран ажиллах цогц арга хэмжээг төлөвлөж, үр дүнг тооцон ажиллана.

АХИС-г нэвтрүүлэх нь зөвхөн сургуулийн ажил биш, эцэг эх, асран хамгаалагчид, бусад талуудын оролцоо, хамтын ажиллагааны үр дүн байдаг. Туршин нэвтрүүлсэн сургуулиудын эцэг эхийн санал бодлоос үзэхэд тэдний 95 хувь нь уг аргыг сургалтад нэвтрүүлж чадвал “казах

хүүхдүүдийн хувьд маш чухал болох"-ыг, "сургалтаа хос хэлээр явуулна гэдэг нь сайхан санаа болох"-ыг онцолсон байна. Тэдний хувьд хүүхдийн "эх хэлний боловсрол ч чухал, төрийн хэл ч чухал" бөгөөд хүүхэд нь "хоёр хэлээ сайн сурвал эцэг эхийн зорилго биелнэ" гэж үзжээ.

Сургуулийн удирдлагын зүгээс сайдын тушаалаар баталсан чиглэлийг хэрэгжүүлэхдээ юуны түрүүнд дараах ажлыг үе шаттай зохион байгуулахыг зөвлөж байна. Үүнд:

- 3-5 дугаар ангид болон 6-12 дугаар ангид монгол хэлээр заах, хос хэлээр зохион байгуулах судлагдахууныг тодорхойлох, ингэхдээ багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөлтэй сайтар хэлэлцэж шийдвэрлэх;
- Үүний үндсэн дээр сургуулийн хос хэлт сургалтын бодлого/чиглэл-зорилго, зорилтыг тодорхойлох;
- Хос хэлт хичээл/сургалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, нийт багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдаар хэлэлцүүлэн баталгаажуулах;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах зэрэг болно.

Үүний тулд сургуулийн удирдлагын зүгээс хос хэлний сургалтын бодлого чиглэлээ тодорхойлох, АХИС-г нэвтрүүлэхийн өмнө сургуулийнхаа өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, уг үнэлгээнийхээ дагуу тодорхой ажлыг төлөвлөх боломжтой. Ингэхдээ дараах асуулгыг ашиглах боломжтой бөгөөд энэхүү асуулгыг ЕАБХАБ-ын Төв Азийн орнуудын Олон хэлт боловсролын хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан шалгуурыг үндэслэн боловсруулсан болно.

Манай сургууль хос хэлний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд бэлэн үү, бид юу хийх хэрэгтэй вэ?

Шалгуур		Үнэлгээ/санал нийлэх эсэх		
		тийм	эргэлзэж байна	үгүй
1. Хос хэлний сургалтын хөтөлбөрийг (ХХСХ) хэрэгжүүлэх урам зориг/хүсэл	Манай сургуулийн сурагчид нь угсаатны болон хэлний бүлгийн төлөөлөл мөн.			
	Бид ХХСХ-ийн зорилгоо тодорхой томъёолон дэвшүүлэхэд бэлэн байна.			
	Манай сургуулийн ХХСХ-ийн зорилго нь улс орныхоо боловсролын бодлоготой уялдсан байна.			
	Манай сургууль хос хэлээр хичээл зааж байсан туршлагатай.			
2. ХХСХ-ийн манлайлал ба төлөвлөлт	ХХСХ-ийг хэрэгжүүлэхийн тулд сургууль үүрэг, хариуцлага хүлээж чадна.			
	Багш нар ХХСХ-ийг хэрэгжүүлэхийн тулд мэдлэг, мэргэжлээ дээшлүүлж чадна.			
	ХХСХ-ийг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн сургалт-арга зүй (ЗАН) болон технологийн нөөцийг дайчлах, нэмэгдүүлэх боломжтой.			
	ХХСХ-ийг хэрэгжүүлэхдээ хөтөлбөрт хамрагдах бүх сурагчдад хэлний чадвар, бэлэн байдлын түвшин, сурлагын амжилт, нийгэм, жендер болон бусад шинж чанараас үл хамааран тэгш боломж олгох арга хэмжээ авна.			
3. Олон хэлний боловсрол дахь эцэг, эх, орон нутгийн иргэдийн дэмжлэг	ХХСХ-ийг хэрэгжүүлэх шийдвэрийг эцэг эх, багш нар, сурагчид зөвшөөрнө.			
	ХХСХ-ийг хэрэгжүүлэхэд эцэг эхчүүд нь туслагч байна.			
	Орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний нөөцийг татан оролцуулах боломжтой.			

Хос хэлт сургалтын төлөвлөлт, хэлний харьцаа


Хос хэлт сургалтын тухайд хэлний харьцааг тогтоох нь чухал байдаг. Тухайлбал, тухайн сургуулийн хувьд аль ангиас, ямар судлагдахууныг хос хэлээр хичээллүүлэхийг тогтоосны үндсэн дээр судлагдахуун бүрийн Х1, Х2-ын харьцааг болон шаардлагатай мэргэжлийн, хэрэглэгдэхүүний, санхүүжилтийн дэмжлэгийг тодорхойлж, түүнийг хаанаас, хэрхэн авахыг төлөвлөгөөндөө тодорхой тусгах хэрэгтэй болдог.

Х1, Х2-ын харьцааг тогтоосон байх нь багш хичээлийн төлөвлөлтөө хийхдээ хичээлийн аль хэсэгт, ямар хугацаагаар, аль хэлээр сурагчидтай харилцах, тэдэнд аль хэл дээр ямар зааварчилга өгөх зэргээ боловсруулахад чухал байдаг. Хэлний харьцааг тогтоохдоо:

- Сурагчдын хэлний түвшин, үгийн нөөц,
- Сурагчийн хэрэгцээ, сонирхол,
- Эцэг, эхийн санал хүсэлт, дэмжлэг,
- Хос хэлээр хичээл зохион байгуулах багш нарын оролцоо,
- Сургуулийн удирдлага болон орон нутгийн боловсролын байгууллагын саналыг харгалзан тэдний оролцоотойгоор тогтооно.

Ялангуяа, дунд ангийн төгсгөл шат, ахлах ангийн сурагчдын хэрэгцээ, сонирхлыг харгалзах нь чухал юм. Тэдний хувьд дараагийн шатны боловсрол эзэмших болон ирээдүйн ажил мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлсон байдаг.

Хэлний харьцааны жишээ загвар:



САЙН ТУРШЛАГА



СУРГУУЛЬ ДАХЬ ОЛОН ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ

Мадина Рысбекова,
указахстан, Шыммент хотын
З.Хусановын нэрэмжит ЕБ-ийн №110
дугаар сургуулийн орос хэл, уран
захиолын багш

З.Хусановын нэрэмжит 110 дугаар сургууль нь 2004 оноос хос хэлт боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Өмнөд Казахстаны бүс нутгийн Боловсролын газрын 2007 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 108 тоот тушаалын дагуу тус сургууль нь хос хэлний боловсролд дэмжлэг үзүүлж байна. Мөн 2010 оны 11 дүгээр сарын 29-ний 1134 тоот тушаалын дагуу тус сургууль нь туршилтын сургууль, олон хэлний боловсролыг нэвтрүүлсэн анхдагч хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн.

Өнөө үед багш нарын өмнө тавигдаж буй үүрэг даалгавар нь төрийн болон орос, англи хэлээр үр дүнтэй харилцах чадвартай бие хүн хүмүүжүүлэх ба олон хэлний боловсрол олгох явдал юм. Манай сургууль үндэсний хэмжээний сургууль боловч сурагчид өөрсдийнхөө төрөлх хэл болох узбек хэлээ сурч байна. Үүнтэй холбоотойгоор манай сургууль олон хэлт болон олон соёлт боловсролыг хэл, соёлын олон янз байдлыг хамгаалах арга зам, олон хэлт иргэн бэлтгэх, иргэний үнэслэмж, хүмүүжил олгох, Казахстаны ард түмний хоорондын харилцан ойлголцлыг бэхжүүлэх арга хэрэгсэл болгон нэвтрүүлж байна.

2004 оноос эхлэн тус сургууль олон хэлт боловсролын хэд хэдэн загварыг хэрэгжүүлсэн.

З.Хусановын нэрэмжит ЕБ-ын 110 дугаар сургуулийн олон хэлний болон хос хэлт боловсролыг хэрэгжүүлэх үе шат ба загвар (2011-2020 оны хичээлийн жил)

<p>2002-2003 оны хичээлийн жил Бэлтгэл үе шат 10-11 дүгээр анги: Төгсөгчдийг их дээд сургуульд бэлтгэсэн. Бүх сорилыг хоёр хэлээр (төрөлх хэл ба казах хэл, төрөлх болон орос хэл) гүйцэтгэсэн.</p>
<p>2003-2005 оны хичээлийн жил 8-9 дүгээр анги: Казахстаны түүх, газарзүй, биологи, физик, хими зэрэг хичээлийг хоёр хэлээр судал-сан: Сурагчийн төрөлх хэл болон төрийн хэл дээр. 10-11 дүгээр анги: Бүх судлагдахууны шалгалт хоёр хэлээр явагдсан: төрөлх хэл ба казах хэл, төрөлх болон орос хэл дээр.</p>
<p>2005-2006 оны хичээлийн жил 1-4 дүгээр анги: Танин мэдэхүйн хичээлүүд, дүрслэх урлаг, хөгжим, хөдөлмөрийн сургалт; 5 дугаар ангиас - Казахстаны түүх, байгалийн ухаан; 6 дугаар ангиас - газар зүй, биологи; 7 дугаар ангиас физик; 8 дугаар ангиас химийн хичээлийг хоёр хэл дээр буюу төрөлх хэл болон төрийн хэл дээр заасан.</p>

<p>2007-2011 оны хичээлийн жил 1-4 дүгээр анги: Танин мэдэхүйн хичээлүүд, дүрслэх урлаг, хөгжим, хөдөлмөрийн сургалтыг хос хэлээр: эх хэл болон төрийн хэл дээр, эх хэл болон орос хэл дээр заасан. 5 дугаар ангиас - Казахстаны түүх, байгалийн ухаан; 6 дугаар ангиас - газар зүй, биологи; 7 дугаар ангиас физик; 8 дугаар ангиас химийн хичээлийг хоёр хэл дээр буюу төрөлх хэл болон төрийн хэл дээр заасан.</p>
<p>2012-2017 оны хичээлийн жил 1-4 дүгээр анги: Танин мэдэхүйн хичээлүүд, дүрслэх урлаг, хөгжим, хөдөлмөрийн сургалтыг хос хэлээр: эх хэл болон төрийн хэл дээр, эх хэл болон орос хэл дээр заасан. 5 дугаар ангиас - байгалийн ухаан, дүрслэх урлаг, хөгжим, хөдөлмөрийн сургалт; 6 дугаар ангиас - газар зүй, биологи; 7 дугаар ангиас физик; 8 дугаар ангиас химийн хичээлийг хоёр хэл дээр: эх хэл болон төрийн хэл дээр, эх хэл болон орос хэл дээр заасан.</p>
<p>2018-2020 оны хичээлийн жил 3, 4 дүгээр анги: Танин мэдэхүйн хичээлүүд, дүрслэх урлаг, хөгжим, хөдөлмөрийн сургалтыг хос хэлээр: эх хэл болон төрийн хэл дээр, эх хэл болон орос хэл дээр заасна. 5-9 дүгээр анги: Байгалийн ухаан, математикийн чиглэлийн хичээлүүдийг эх хэл болон орос хэл дээр, хүмүүнлэгийн хичээлүүдийг эх хэл болон казах хэл дээр заасна.</p>

Жил бүр манай сургууль дээр олон хэлний боловсролын салбарын шинжээч зөвлөхүүд оролцсон орчин үеийн хос хэлт боловсролын янз бүрийн тулгамдсан асуудлыг хөндсөн олон улсын эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурал зохион байгуулагддаг.

Түүнчлэн сургууль нь хөрш зэргэлдээ орны төлөөлөгчдөөс ихээхэн талархал хүлээн, өндөр үнэлгээ авч байгаа сургалт-семинар, нээлттэй хичээлүүдийг зохион байгуулдаг.

Сургалтын чанарыг сайжруулахын тулд интерактив арга зүйг нэвтрүүлж байна. Багш нарын үүрэг бол сурагч бүрд амжилтад хүрэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх явдал юм.

Үүний зэрэгцээ манай багш нар судалгааны аргыг хэрэглэдэг: бие дааж хичээлд бэлтгэх зорилгоор сурагчдад шүүмжлэлийн болон уран сайхны зохиолын жагсаалтыг санал болгодог.

Бид төгсөгчиддөө хэлний үр чадвараа хөгжүүлэх, соёл хоорондын харилцааны чадвараа хөгжүүлэх, чанартай боловсрол эзэмших зэрэг өргөн боломжийг нээж өгдөг. Мөн тэдний олонх нь хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор мэргэжлийн бэлтгэл хийх давуу талтай байдаг.

Эх сурвалж. Диалог, Төв азийн орнууд дахь олон хэлт болон олон соёлт боловсролын мэдээлэл-арга зүйн хөтөч, №1, 10 тал

ЗАРИМ НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

Нэр томьёо		Тайлбар
Монгол	Англи	
Агуулга болон хэлийг интеграцлан суралцахуй	Content and Language Integrated Learning (CLIL)	Хэлний хичээлээс бусад судлагдахууны агуулгыг тухайн сурагчийн судалж буй зорилтот хэлээр заах сургалт, боловсролын үйл ажиллагаа
Эх хэл	Mother Tongue	Төрөлх хэл, өөрийн үндэсний хэл
Зорилтот хэл	Target language	Сурагчийн сурахыг зорьж буй, заавал сурсан байх хэл, тухайлбал, казах хүүхдүүдийн хувьд монгол хэл болно.
Хэл 1, Хэл 2.... (X1, X2)	Language 1, (L1) language 2 (L2)	X1- Эх хэл – судалгааны хүрээнд казах хэл X2- Монгол хэл – судалгааны хүрээнд сурагчийн заавал эзэмших хэрэгтэй монгол хэл
Төрийн хэл	State language	Төрийн бодлогоор статус тогтоосон, давамгайлах хэл 4.1.1.“төрийн албан ёсны хэл” гэж төрийн байгууллага, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөх орчин цагийн утга зохиолын монгол хэлийг; (МХТХ, 2015)
Гэрийн хэл	Home language	Сурагчийн гэртээ ярьдаг хэл, зарим сурагч гэртээ 2 хэлээр ярьдаг
Олон (хос) хэлт боловсрол	multilingual education bilingual education	- Олон хэлт боловсрол, хос хэлт боловсрол - Хоёр болон түүнээс олон хэлээр боловсрол эзэмших үйл явц

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

- Монгол Улсын Их Хурал, Боловсролын ерөнхий хууль, 2023 он
- Монгол Улсын Их Хурал. (2023). Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, 2023 он
- Засгийн Газрын 2024 оны 176 дугаар тогтоол, Үзэл баримтлал батлах тухай
- Боловсролын сайдын 2025 оны А/229 тушаал, “Хос хэлний сургалтын талаар баримтлах чиглэл” батлах тухай;

Судалгаа, ном, сэтгүүл

- Боловсролын хүрээлэн, “АХИС-г туршин нэвтрүүлэх судалгааны тайлан”, УБ, 2021-2022
- Kathleen Heugh, Multilingual Education: Contexts, theories and practices 4th International Conference on Language and Education: Multilingual Education for All in Asia and the Pacific – Policies, Practices and processes, Bangkok, 2013
- Стоянова.А, Глушкова.М, “Как разработать и внедрить устойчивую программу многоязычного образования”, Руководство по проектированию и реализации многоязычных программ, Бишкек, 2016);
- Стоянова.А, Глушкова.М, “Ключевые аспекты многоязычного и поликультурного образования”, Бишкек, 2020;
- Нэнси.Х.Х, Райт.У, “Основы билингвального образования и билингвизма”, Бишкек, 2017;
- Liz Dale, Rosie Tanner “CLIL Activities”, Cambridge University press, 2012;
- БСҮХ, ДБ, (2023), Агуулга болон хэлийг интеграцлан суралцахуй-АХИС
- Диалоги, Төв азийн орнууд дахь олон хэлт болон олон соёлт боловсролын мэдээлэл-арга зүйн хөтөч, №16, 17, 18, 2018 он.

Зөвлөмжийг боловсруулсан баг:

Багийн ахлагч:

Ж.Зүлмира, БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Гишүүд:

С.Ерия, Баян-Өлгий аймгийн Боловсролын газрын ахлах арга зүйч

Б.Гүлжан, Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын V сургуулийн
бага ангийн сургалтын менежер

Ж.Сайрангүл, Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын V сургуулийн
математикийн багш

Зөвлөх:

У.Туяа (Ph.D), БСҮХ-ийн зөвлөх

Эксперт:

Л.Батсүрэн, БЕГ-ын мэргэжилтэн

